



УЛС ТӨРИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГООР ДАМЖУУЛАН АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ



Зохиогчийн эрх

©Конрад-Аденауэр-Сан
Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар
Сөүлийн гудамж, Браухаус-22
Улаанбаатар хот
Монгол Улс

Орчуулсан: Хасбаганын Ариунчимэг
Хасбаганын Чинбат
Хянасан: Др. Даниел Шмюкинг
Батмөнхийн Дөлгөөн
Изабелл Кюллер
Рафаэлла Хэлф

Улаанбаатар хот, 2017 он

АГУУЛГА

- 4 | **ӨМНӨХ ҮГ**
Пунсалмаагийн Очирбат
/Монгол Улсын анхны Ерөнхийлөгч бөгөөд Монгол-Германы Чуулганы Тэргүүн/
- 6 | **МЭНДЧИЛГЭЭ**
Штефан Дуппел
/ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд/
- 8 | **МОНГОЛ-GERМАНЫ ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**
Лувсанвандангийн Болд
/МУ-ын УИХ-ын гишүүн, Монгол-Германы Чуулганы Дэд ерөнхийлөгч/
- 11 | **МОНГОЛ-GERМАНЫ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**
Дэндэвийн Тэрбишдагва
/МУ-ын УИХ-ын гишүүн, Монгол-Германы парламентын бүлгийн Дарга/
- 17 | **ХБНГУ-ЫН УЛС ТӨР ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮД – ӨНГӨРСӨН БА ОДОО ЦАГТ**
Кристине Лийберкнехт
/ХБНГУ-ын Тюринген муж улсын Ерөнхий сайд асан, Тюринген муж улсын Ландтагийн гишүүн/
- 24 | **МОНГОЛ УЛС ДАХЬ АРДЧИЛЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨР ДЭХ ОРОЛЦОО**
Агваанлуvsангийн Ундраа
/МУ-ын УИХ-ын гишүүн/
- 33 | **“УЛС ТӨР ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮД: СААД БЭРХШЭЭЛ БОЛОН БОЛОМЖУУД” ПАНЕЛ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ОНЦЛОХ ЭШЛЭЛҮҮД**
Ринчиннямын Амаржаргал
/МУ-ын 21 дэх Ерөнхий сайд бөгөөд МУ-ын УИХ-ын гишүүн асан/
Батхуягийн Золзаяа
/Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ-ын Захирал/
Кристине Лийберкнехт
/ХБНГУ-ын Тюринген муж улсын Ерөнхий сайд асан, Тюринген муж улсын Ландтагийн гишүүн/
Загдхүүгийн Нарантуяа
/МУ-ын УИХ-ын гишүүн/
- 35 | **ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД БА ТЭДГЭЭРИЙН ХҮРЭЭН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО**
Беате Транкманн
/НҮБ-ын болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь Суурин төлөөлөгч/
- 39 | **ЧУУЛГАНЫ ХҮРЭЭН ДЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД**
Хуягийн Номингэрэл
/Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ-ын УЗ-ийн дарга/
- 41 | **ТӨГСГӨЛ ҮГ**
Др. Даниел Шмюкинг
/Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч/
- 42 | **МОНГОЛ-GERМАНЫ XIV ЧУУЛГАН ФОТО ДУРАНД**

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо!



Уламжлал ёсоор жил бүр зохион байгуулагддаг Монгол-Германы Чуулганы ээлжит бага хурлуудаар бид анх монголын шинэ залуу ардчиллыг бэхжүүлэх, түүний өрнөл дэвшилд дэмжлэг үзүүлэх болон манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэх, улс орны эдийн засгийн хөгжлийн гарц шийдлийг зөв олж, харилцан ашигтай хамтын ажиллагааны замаар мөр зэрэгцэн урагшлахтай холбоотой, гол төлөв хоёр талын хамтын ажиллагаанд холбогдох асуудлуудыг түлхүү хэлэлцдэг байсан бол сүүлийн жилүүдэд Монгол Улс Ази тив, бүс нутгийн интеграцид болон аюулгүй байдалд чиглэсэн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох боломж бололцоо хийгээд хүчин чармайлтын тухай асуудлыг авч ярилцдаг болж байна.

*Монголын нийгэм,
залуу ардчилал
маань хөгжлийнхөө
хариуцлагатай үед
яваа энэ үед манай
нийгмийн гишүүдийн
тэн хагасыг эзэлдэг
эмэгтэйчүүдийг
шийдвэр гаргах
түвшинд идэвхтэй
оролцуулах асуудал
зөвхөн манай орны
төдийгүй ер нь
ардчиллын цаашдын
хөгжлийн чухал
асуудал болсоор
байна.*

Бидний санал бодлоо солилцож, үйл ажиллагаагаа чиглүүлдэг сэдэв цаашид хүрээгээ тэлж Ази, Европын хамтын ажиллагааны асуудал, тухайлбал АСЕМ-ын дээд хэмжээний 11 дүгээр уулзалттай холбоотой асуудлын талаар өнгөрсөн жил Берлин хотноо болсон 13 дугаар бага хурлаараа хэлэлцэн улмаар санал бодлоо хоёр орны холбогдох дээд байгууллагуудын сонорт хүргэж байсан билээ. Энэ удаагийнхаа бага хурлаар бид Монгол-Германы харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар ярилцахаас гадна манай хоёр орны хувьд хамтын үнэт зүйл болох ардчиллын цаашдын хөгжил, тухайлбал ардчилсан нийгэмд эмэгтэйчүүдийн үүрэг ролийг дээшлүүлэх, ялангуяа шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, бэхжүүлэхтэй холбогдсон нэн чухал асуудлыг авч хэлэлцэх гэж байна.

Монголын нийгэм, залуу ардчилал маань хөгжлийнхөө хариуцлагатай үед яваа энэ үед манай нийгмийн гишүүдийн тэн хагасыг эзэлдэг эмэгтэйчүүдийг монголын нийгэм эдийн засгийн хөгжил, төр засгийг удирдах ажил үйлсэд болон ялангуяа аливаа шийдвэр гаргах түвшинд идэвхтэй оролцуулах асуудал зөвхөн манай орны төдийгүй ер нь ардчиллын цаашдын хөгжлийн чухал асуудал болсоор байна. Энэ утгаар авч үзвэл ардчиллын хөгжилд германы эмэгтэйчүүдийн оруулж буй үнэт хувь нэмрийн талаар энэ удаагийн бага хурал дээр эрхэмсэг хатагтай Кристине Лийберкнехтийн тавих илтгэл бидний анхаарлыг онцгой татаж байна. Түүнчлэн энэ удаагийн хуралдааны үеэр манай талаас тавих илтгэлүүд, монгол, германы эмэгтэйчүүдийн оролцоотойгоор зохиогдох „Улс төр дэх эмэгтэйчүүд: Саад бэрхшээл болон боломжууд” сэдэвт хэлэлцүүлэг зэрэгт та бүхэн нэн идэвхтэй оролцож санаа бодлоо уралдуулна гэдэгт би итгэлтэй байна.

Хатагтай, ноёд оо!


2016 он Монгол Улсын маань хувьд онцгой үйл явдлаар баялаг жил болж байна. Бид улс орныхоо түүхэн тэмдэглэлт ой, үйл явдлуудаа сайхан тэмдэглэж өнгөрүүлээ.

Монгол оронд маань АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт амжилттай болж өнгөрлөө. Энэ хүрээнд тус хоёр тивийн улс гүрнүүдийн парламент, залуучууд, эмэгтэйчүүд, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон эдийн засаг, бизнесийн хүрээнийхний зэрэг өргөн төлөөлөл бүхий уулзалтууд болж өнгөрсөн билээ. Энэ бүхэн манай ардчилсан хөгжлийн үйл явцад үр өгөөжөө хайрласан, Монгол Улсын маань олон улсын байр суурь, жин нөлөө, нэр хүндийг цаашид дээшлүүлэхэд ач холбогдлоо өгсөн гэдэгт би итгэлтэй байна.

Түүнчлэн энэ жил Улсын Их Хурал - парламентын ээлжит сонгууль амжилттай явагдаж монголын ардчиллын хөгжилд бас нэгэн шинэ хуудсыг нээлээ. Энэ сонгууль ардчиллын хөгжлийг цаашид түүштай өрнүүлэн бэхжүүлэх, амжилт алдаагаа зөв дүгнэж хэтийн ирээдүйгээ саруулхан харж байхын чухлыг дахин харууллаа. Ардчиллыг өргөжүүлэн бэхжүүлэх, нийгэм, олон нийтийн дуу хоолойг сонор соргог сонсож, улс төрийн өндөр мэдрэмжтэй байхын чухлыг энэ удаагийн сонгууль улс төрийн намуудад дахин санууллаа гэж би бодож байна.

Энэ удаагийн сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдсэнд монголын олон нийт ихэд олзуурхаж байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд алхам хийлээ гэж харж байгаа юм. Чухам ийм үед Монгол-Германы форум энэ асуудлаар санал бодлоо солилцож төр засгийнхаа удирдлагад болон монголын нийгэмд шинэ дохио санаа өгөх зорилго тавьж байгаа нь чухал ач холбогдолтой гэж бид үзэж байна. Энэхүү асуудлыг энэ удаагийн бага хурлын гол сэдэв болгон авч хэлэлцэх талаар бидэнтэй санал нэгдэж, уламжлал ёсоор бүх талын тус дэмжлэг үзүүлж буй ХБНГУ-ын КАС, түүний Монгол дахь Суурин төлөөлөгч ноён Даниел Шмюкинг, Суурин төлөөлөгчийн газрын ажилтан нарт гүн талархал илэрхийлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.



Пунсалмаагийн Очирбат

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч бөгөөд
Монгол-Германы Чуулганы Тэргүүн

Энэ удаагийн
сонгуулийн үр
дүнгээр Улсын
Их Хурал дахь
эмэгтэйчүүдийн
төлөөлөл нэмэгдсэнд
монголын олон нийт
ихэд олзуурхаж
байна.

Өөрөөр хэлбэл, улс
төрийн шийдвэр
гаргах түвшинд
эмэгтэйчүүдийн
оролцоог нэмэгдүүлэх
чиглэлд алхам хийлээ
гэж бид харж байгаа
юм.

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт профессор Очирбат,
Эрхэм хүндэт Герман болон Монгол Улсын
парламентын гишүүд,
Эрхэм хүндэт ноён др. Шмюкинг болон
Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

миний бие өнөөдөр та бүхний хамт энэ удаагийн
Монгол-Германы Чуулганыг нээх завшаан тохиосонд
баяртай байна.

Тус чуулган нь олон жилийн уламжлалтай билээ.

14 дэх удаа чуулж буй Монгол-Германы Чуулган нь
эрх чөлөө, хүний эрх болон ардчиллын үнэт зүйлс
дээр суурилсан манай хоёр орны итгэлт харилцааны
илэрхийлэл болсоор ирсэн.

*14 дэх удаа
чуулж буй
Монгол-Германы
Чуулган нь эрх чөлөө,
хүний эрх болон
ардчиллын үнэт
зүйлс дээр суурилсан
манай хоёр орны
итгэлт харилцааны
илэрхийлэл
болсоор ирсэн.*

Өмнөх үеийн төрийн тэргүүнүүд тус чуулганыг санаачлан
эхлүүлснээрээ манай хоёр орны харилцааны чухал нэгэн
хэлэлцүүлгийн талбарыг бий болгох үндсийг тавьж өгсөн.

Миний бие албан үүргээ хүлээж аваад Монгол Улсын
өнөөгийн Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржид бараалхсан анхны
өдөр тэрээр мөн энэ тухай дурьдаж байсан нь надад таатай
сэтгэгдэл төрүүлсэн.

Ажлын маань албан ёсны эхний өдөр буюу энэ оны 7 дугаар
сард миний бие итгэмжлэх жуух бичгээ өргөн барьсны
дараа тэрээр ардчиллыг бэхжүүлэх үйл явц дахь Герман-
Монголын уламжлалт хамтын ажиллагаанд онцлон чухал
холбогдол өгч, цаашид үргэлжлүүлэхийг уриалсан.

Герман Улс монголын ардчиллыг дэмжсээр ирснийг
илэрхийлэх нэгэн арга хэмжээнд өнөөдөр та бид хүран
чуулж байгаа бөгөөд үүнд германы улс төрийн сангууд
гол түүншүүдийн хувиар олон жил чухал үүрэг гүйцэтгэн
оролцдогийг энд онцлон тэмдэглэхгүй байхын аргагүй
юм. Нэн ялангуяа Конрад-Аденауэр-Сан Монгол дахь
шилжилтийн үйл явцыг өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд
дэмжсээр ирсэн.

Конрад-Аденауэр-Сан үйл ажиллагааныхаа хүрээнд
эмэгтэйчүүдийг дэмжихэд онцгойлон ач холбогдол өгдөг
бөгөөд энэ жилийн Монгол-Германы Чуулганыг "Улс төрийн
шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоогоор
дамжуулан ардчиллыг бэхжүүлэх нь" сэдвээр зохион
байгуулж байна.

Чуулганы зорилго нь шийдвэр гаргах түвшин дэх
эмэгтэйчүүдийн оролцоог хүлээн зөвшөөрөгдөхөд дэмжлэг
үзүүлж, эдийн засаг, нийгэм болон нэн ялангуяа улс төрийн
салбарын удирдах албан тушаалд эмэгтэйчүүд ажиллах
өргөн боломжийг бэхжүүлэх явдал юм.

Энэ жилийн 6 дугаар сард болсон сонгуулийн үр дүнд Монгол
Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн тоо хоёроор нэмэгдэж,
парламентын 76 гишүүний 13 суудлыг эмэгтэйчүүд эзэлж
байна.

Энэ нь багахан ахиц дэвшил мэт боловч хөгжил зөв зүгт чиглэж буйг бид үүнээс харж болох юм. Зөвхөн Монгол Улс биш бид бүгд энэ замаар урагшлах учиртай.

Герман Улсын хувьд ч энэ асуудлын хүрээнд сайжруулах зүйлс бий. Манай улсын парламентад мөн эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаа бөгөөд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь өөрийн аясаар биеллээ олчихдог зүйл биш юм.

Иймээс энэ асуудлыг шийдвэрлэх хүрээнд хамтран ажиллацгаая.

Өнөөдөр энд хуран цугласан чухал олон төлөөллийн тусламжтайгаар бид үүнийг бүтээж чадна!

Чуулганы нийт оролцогчдод хоорондоо үнэт мэдээллээ солилцон, үр өгөөжтэй хэлэлцүүлэг өрнүүлэн, цаашид хөглөгдөх олон санааг олж нээхийг хүсье.

Гүн талархал илэрхийлье!

Штефан Дуппел

*ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт
Элчин сайд*

*Шийдвэр гаргах
түвшин дэх*

*эмэгтэйчүүдийн
оролцоог*

*нэмэгдүүлэх нь
өөрийн аясаар
биеллээ олчихдог
зүйл биш юм.*

*Иймээс энэ асуудлыг
шийдвэрлэх хүрээнд
хамтран ажиллацгаая.*

МОНГОЛ-GERMAHЫ XAPИЛЦAАHЫ ӨHӨӨГИЙH БАЙДАЛ

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,



*Герман Улс бидний
хамгийн дотны түнш
улсуудын нэг бөгөөд
манай орны Европ
тив дэх гол түнш мөн
манай "Гуравдагч
хөрш орон" билээ.*

18 жилийн өмнө тухайн үеийн ХБНГУ-ын Ерөнхийлөгч асан ноён Р. Херцог Монголд зочлох үеэр хоёр орны иргэний нийгмийн хооронд харилцан ярианы механизм бий болгох нэгэн хамтын санаачилга гарсан бөгөөд надад Улсын Их Хурлын гишүүн, Монгол-Германы парламентын бүлгийн даргын хувьд Монгол-Германы Чуулганыг (МГЧ) хамтран зохион байгуулалцах боломж олдсон юм. Тус чуулган нь манай хоёр орны ард түмний харилцан ойлголцолд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготой бөгөөд тус үүргээ өнөөг хүртэл маш амжилттай биелүүлж байна. Энэхүү нэр хүндтэй арга хэмжээнд дахин оролцох боломж олдсонд их баяртай байна. Ингээд миний бие Монгол-Германы харилцааны талаар бэлтгэсэн богино илтгэлээ та бүхэнд хүргэе.

2014 онд намайг Монгол Улсын Гадаад хэргийн сайд байх үед бид Монгол Улс, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн. 2014 оны долдугаар сард тус баярын оргил болж ХБНГУ-ын

Гадаад хэргийн сайд Франк-Валтер Штайнмайер Монгол Улсад айлчлал хийснийг эргэн санахад таатай байна. 2015 оны аравдугаар сард эрхэм хүндэт Холбооны Ерөнхийлөгч Йоахим Гаук манай улсад айлчилж мөн хоёр сарын өмнө эрхэм хүндэт Холбооны Канцлер хатагтай Ангела Меркел Улаанбаатар хотод зохиогдсон АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтанд хүрэлцэн ирсэн билээ. Энэ нь түүний 2011 оны аравдугаар сард Засгийн газрын тэргүүний хувьд манай оронд хийсэн албан ёсны айлчлалаас хойшхи 2 дох айлчлал нь байлаа.

Эдгээр дипломат айлчлалууд Монгол Улс болон ХБНГУ-ын хоорондох улс төрийн харилцаа маш сайн хөгжсөн гэдгийг батлан харуулж байна. Бид ийм төрлийн хоёр талт харилцааг "иж бүрэн түншлэлийн харилцаа" хэмээн тодорхойлдог. Герман Улс бидний хамгийн дотны түнш улсуудын нэг бөгөөд манай орны Европ тив дэх гол түнш мөн манай "Гуравдагч хөрш орон" билээ. Эдгээр тогтмол зохион байгуулагдаж байгаа өндөр хэмжээний айлчлалууд болон хоёр орны харилцааны суурь болсон гэрээ, хэлэлцээрүүдийг цаашид улам өргөжүүлэх нь бидний харилцааг бэхжүүлэхэд чухал түлхэц болно. Афганистан Улсад манай хоёр орны хамтран гүйцэтгэж байгаа энхийг сахиулах зэвсэгт хүчний ажиллагаа, "Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр", "Биометрийн цахим дипломат паспорт эзэмшигчдийг виз авах шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр" болон Монгол Улсын Засгийн газрын 2013 оны тавдугаар сард баталсан ХБНГУ-ын иргэд 30 хүртэлх хоногийн хугацаанд Монгол Улсад визгүй зорчих шийдвэр зэрэг сүүлийн үед байгуулсан гэрээнүүд мөн Монгол-Германы хамтарсан "Ашигт малтмал

технологийн их сургууль"-г байгуулсан зэрэг нь манай хоёр орны хамтарсан олон ажлын тодорхой эерэг жишээ болж байна. Монгол Улс "Гуравдагч хөршийн бодлого"-нхоо хүрээнд Монгол-Германы хоорондох иж бүрэн түншлэлийн харилцааг цаашид стратегийн түншлэл болгон өргөтгөхийг эрмэлзэж байна.

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

Монгол-Германы харилцаа нь олон талт, өргөн утга агуулгаар баян, өн удаан жилийн түүхт харилцаа юм. ХБНГУ-ын Тюринген муж улсаас уг чуулганд хүрэлцэн ирсэн хүндэт зочидтой холбогдуулан Монгол Улс болоод БНАГУ-ын хамтын ажиллагааг магтан дурсмаар байна. БНМАУ болон БНАГУ-ын хамтын ажиллагаа нь Монголын хувьд их үр өгөөжтэй байсан. 20 мянга гаруй монголчууд зүүн Германд их, дээд сургуульд суралцах буюу мэргэжил дээшлүүлсэн. Тэдгээр монголчууд техникийн мэдлэг олж авахаас гадна, герман хэл сурч, ингэснээрээ Маркс, Энгельсээс гадна Гёте болон Шиллерийн бүтээлүүдийг унших чадвартай болсон юм. Олон монголчууд социализмын үед "Вартбург" машинаар дамжуулан Вартбург бай Айзенах хотыг мэддэг болсон. Социалист ахан дүүсийн барилдлагын үеэс мөн Тюринген мужийн нийслэл Эрфурт хотын нэгэн гудамжийг Улаанбаатарын гудамж хэмээн албан ёсоор нэрийдэж ирсэн. Уг гудамжны нэр нь одоо ч хэвээр байгаад бид Эрфурт хот болон Тюринген муж улсад их талархаж байна.

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

Сүүлийн жилүүдэд бид Монгол-Германы эдийн засгийн томоохон төслүүдийн талаар олон таа хэлэлцүүлэг өрнүүлсэн. Монгол Улсын нэгэн сайд 3-4 жилийн өмнө Европын Холбоо болон ХБНГУ-ын хөгжлийн тусламжаас татгалзах саналтай байлаа. Түүхий эдийн үнэ огцом унаж болох тухай хэн ч тухайн үед бодохыг хүсээгүй учраас тэр. Харамсалтай нь бидний эдийн засгийн төслүүдээс бараг аль нь ч бүтсэнгүй. Харин одоо бидэнд Германы хөгжлийн тусламж урьд урьдынхаасаа илүү хэрэгтэй байна. Нүүрс шингэрүүлэх, Тайссэн Круппт коксжсон нүүрс нийлүүлэх, газрын ховор элементийг олборлох зэрэг төлөвлөсөн томоохон төслүүд дээр монголын тал даалгавраа гүйцэтгэх чадваргүй байна. Өөрөөр хэлбэл бид анхны хөрөнгө оруулалтын ноогдол санхүүжилтээ гаргаж чадахгүй байна. Тиймээс өнөөдөр бидэнд реалист хандлага болон эдийн засгийн харилцааны шинэ эхлэл хэрэгтэй байна. Мөн Орос болон Хятад орнуудын ашиг сонирхлыг ч харгалзаж үзэх хэрэгтэйг санах хэрэгтэй.

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

Манай хоёр орны ард түмэн Монгол-Германы найрсаг харилцааг өндрөөр үнэлдэг. Олон монголчууд Герман Улсад ойр сэтгэлтэй бөгөөд тус улсыг ихээхэн хүндэтгэдэг. КАС болон Монгол-Германы Чуулган нь манай нийгэм дэх Герман Улсын талаарх эерэг сэтгэгдлийг хадгалахад ихээхэн хүчин зүтгэл гаргаж, хувь нэмрээ оруулж байгаа.

Өнөөдрийн МГЧ-ны XIV Бага хурал Монгол дахь ардчиллын тухай ойлголтыг сайжруулах болон Монгол-Германы нөхөрлөлийг гүнзгийрүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулна гэдэгт би итгэлтэй байна.

Монгол Улс
"Гуравдагч хөршийн
бодлого"-нхоо
хүрээнд
Монгол-Германы
хоорондох иж
бүрэн түншлэлийн
харилцааг цаашид
стратегийн түншлэл
болгон өргөтгөхийг
эрмэлзэж байна.

*Парламентын
ардчилал, хүний эрх
болон улс төрийн
шийдвэр гаргалтын
ил тод байдал зэрэг
сэдвүүд нь манай
улсын өнөөгийн улс
төрийн хүчнүүдийн
харьцаанаас
шалтгаалан хурцаар
хөндөгдөж байна.*

Парламентын ардчилал, хүний эрх болон улс төрийн шийдвэр гаргалтын ил тод байдал зэрэг сэдвүүд нь манай улсын өнөөгийн улс төрийн хүчнүүдийн харьцаанаас шалтгаалан хурцаар хөндөгдөж байна. Улс орны өнөөгийн эдийн засгийн болон улс төрийн хөгжлийн тухай бид өнөөдөр олон талаас нь нээлттэй хэлэлцэнэ гэдэгт миний бие итгэж байна.

Энд хүрэлцэн ирсэн зочид болон Монгол-Германы Чуулганы XIV Бага хуралд өндөр амжилт хүсье!

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Лувсанвандангийн Болд

*МУ-ын УИХ-ын гишүүн,
Монгол-Германы Чуулганы Дэд ерөнхийлөгч*

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

Юуны өмнө энэхүү бага хуралд морилон ирсэн та бүхэнд УИХ дахь Монгол-Германы парламентын бүлгийн гишүүдийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байгааг минь хүлээн авна уу.

Өнөөдрийн энэхүү бага хуралд оролцож Монгол-Германы харилцааны өнөөгийн хөгжил, хэтийн төлөвтэй холбоотой асуудлаар үг хэлэх боломж олгосон явдалд МГЧ-ны удирдлага болон КАС-ийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрынханд талархал илэрхийлье.

Монгол-Германы харилцааны асуудал бол МГЧ хэмээх энэхүү ТББ-ыг анх байгуулагдсан үеэс тус форумын анхаарлын төвд байсаар ирсэн гол сэдвийн нэг мөн бөгөөд манай хоёр орны хамтын ажиллагааны боломжуудын талаар өнөөдөр дахин хөндөж буй нь харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө та бүхний тавьж буй онцгой анхаарлын тод илрэл төдийгүй түүний хөгжил дэвшилд оруулж буй чухал хувь нэмэр гэж би үзэж байна.

Хатагтай, ноёд оо,

Өнгөрсөн зууны 90-ээд оноос эхлэн Монголын гадаад бодлогод гуравдагч хөрштэй харилцах бодлого чухал байр суурь эзэлж ирсэн билээ. Монгол Улсын гадаад бодлогын нэгэн гол тулгуур болсон “Гуравдагч хөрштэй” харилцах бодлогыг бид нэг талаас нийгмийн байгууллын хувьд ардчилсан бөгөөд эдийн засгийн хувьд хөгжингүй, нөгөө талаас Монгол Улстай найрсаг харилцаатай орнуудтай харилцах бодлого гэж ерөнхийдөө ойлгож ирсэн бөгөөд үүнийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг төрийн бодлогын суурь баримт бичгүүддээ тусган баталгаажуулсан байдаг. Тэрхүү гуравдагч хөрш орнуудын чухал төлөөллийн нэг нь Европын Холбоон дахь манай гол түнш болох ХБНГУ юм. Нэгдсэн Герман Улстай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаагаа цаашид улам бэхжүүлж, өргөжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын эрхэм чухал зорилтын нэг байсаар ирсэн бөгөөд цаашид ч байх учиртай гэж бид үздэг билээ.

Монгол орон ардчиллын замыг тууштай сонгож, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлийг зэрэг хийж эхэлсэн 90-ээд оноос хойш Монгол Улсыг тууштай дэмжиж ирсэн ХБНГУ-д манай ард түмэн гүнээ талархаж байдаг юм.

Хатагтай, ноёд оо,

Герман, Монголын харилцаа олон салбарт амжилттай хөгжиж байгаа бөгөөд ялангуяа улс төрийн түвшинд сүүлийн жилүүдэд хамгийн идэвхтэй хөгжиж байна.



Нэгдсэн Герман Улстай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаагаа цаашид улам бэхжүүлж, өргөжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын эрхэм чухал зорилтын нэг байсаар ирсэн бөгөөд цаашид ч байх учиртай гэж бид үздэг.

*Харилцааныхаа
энэ түвшинг улам
ахиулж, стратегийн
түншлэлийн
харилцаанд
шилжих нь эдүгээ
бидний өмнө
тавигдаж буй зорилт
болж байна.*

Өрнөдийн орнуудаас хамгийн түрүүнд буюу 1995 онд Монгол Улс, ХБНГУ хоорондын харилцааны үндсийн тухай Хамтарсан тунхаглалд гарын үсэг зурж хамтын ажиллагааны үндсэн зарчим, чиглэлүүдийг тогтоож байсан бол Холбооны Ерөнхийлөгч Х.Келер Монгол Улсад 2008 онд төрийн айлчлал хийх үеэр хоёр орны хооронд "Иж бүрэн түншлэлийн харилцаа"-ны тухай хамтарсан тунхаглалд гарын үсэг зурсан нь хоёр орны нийт харилцааг шинэ шатанд гаргах чухал алхам болсон юм. Харилцааныхаа энэ түвшинг улам ахиулж, стратегийн түншлэлийн харилцаанд шилжих нь эдүгээ бидний өмнө тавигдаж буй зорилт болж байна.

Холбооны Ерөнхийлөгч 2008 онд, Холбооны Канцлер 2011 онд манай улсад албан ёсоор тус тус айлчилсан хийгээд энэ оны долдугаар сард болсон АСЕМ-ын дээд түвшний уулзалтад Холбооны Канцлер хатагтай А. Меркел морилон ирж оролцсон зэрэг нь энэ чиглэлд тавьж буй бидний хамтын чармайлтын үр дүн юм. Дээд түвшний харилцан айлчлалын давтамжийг цаашид ийнхүү хадгалах нь бүх салбарт хамтын ажиллагаа өргөжин тэлэхэд чухал түлхэц болох учиртай.

Монгол Улс нь Азийн бүс нутагт байгаа орнуудаас герман хэлтэй иргэдийнхээ тоогоор тэргүүлэх эгнээнд явдаг бөгөөд монгол, германы харилцаа, хамтын ажиллагаа өдий зэрэгтэй өргөжин хөгжихөд Германд сурч, ажиллаж, энэ ард түмний хэл соёлоор дамжуулан олон зүйлийг сурч эзэмшиж, тусгаж шингээж авсан олон арван мянган монголчууд төдийгүй Монголд болон Германд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, холбоо, нийгэмлэгүүд, хувийн хэвшлийнхэн, түүний дотор Конрад-Аденауэр-Сан зэрэг улс төрийн сангуудын төлөөлөл чухал хувь нэмэр оруулж ирснийг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Хатагтай, ноёд оо,

Монгол, Германы нийт харилцаанд эдүгээ амжилттай хөгжин чамлахааргүй ахиц дэвшил гаргасаар байгаа улс төр, шинжлэх ухаан, соёл боловсрол, батлан хамгаалах болон хүмүүнлэгийн салбарын харилцаанаас гадна хөрөнгө оруулалт, эдийн засгийн салбарын хамтын ажиллагаа чухал байр суурийг эзэлдэг билээ. Монгол, Германы бизнесийн хамтын ажиллагаанд Та бидний буй болгосон хамгийн чухал ололт нь хамтран ажиллах хүсэл эрмэлзэл болон хууль эрх зүйн орчныг бүрэлдүүлээд буй явдал гэж би үзэж байна.

Эдийн засгийн салбарт гуравдагч хөрш орнуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх нь Монгол Улсын хөгжлийн болон аюулгүй байдлын чухал ашиг сонирхол байдаг. Энэ үүднээс манай улс гуравдагч хөрш орнуудын хөрөнгө оруулалтыг аль болох нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Герман Улс Европ дахь Монгол Улсын хамгийн ойр түнш орон гэж монголчууд бид үздэг учраас Германы хөрөнгө оруулалтад тааламжтай нөхцөл бүрдүүлж, дэмжих чиглэлээр бодит ажлууд хийхэд урьдын адил анхаарсаар байна.

Монгол Улс эрдэс баялаг, түүхий эдээ ашиглан нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгийн бодит өсөлт бий болгох үндсэн тулгуурын нэг нь Германы хөрөнгө оруулалтыг татах, тус улсын өндөр технологийг

өөрийн орондоо нутагшуулах, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх явдал юм. Цаашлаад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд, ялангуяа хэрэглэгчдийнх нь худалдан авах чадвар өндөр байдаг Европын Холбооны улсуудад гаргах нь мөрөөдөл төдий зүйл биш бодит ажил болох учиртай.

Эрдэс баялаг, түүхий эдийн нийлүүлэлтийн аюулгүй байдлаа хангах үүднээс Герман Улс энэ салбарт хэрэгжүүлэх стратегийн бодлогоо 2010 онд боловсруулж, байгалын баялгийн арвин нөөцтэй цөөн оронтой түншлэлийн хэлэлцээр байгуулахаар тогтсоны нэгэнд Монгол Улсыг багтаасныг бид талархан хүлээж авсан билээ. Түүнчлэн Холбооны Канцлер А. Меркел 2011 онд Монгол Улсад албан ёсоор айлчлах үеэрээ “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурснаар энэхүү үйл явдал баталгаажиж, улмаар герман талаас томоохон хөрөнгө оруулалт орж ирэхээр яригдсан билээ. Дэлхийн зах зээл дээр эрдэс баялгийн үнэ огцом унасан, Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн байдал сайнгүй байгаа зэрэг нь зөвхөн түр зуурын, цаг хугацааны асуудал бөгөөд цаашид байдал сайжирч бидний ярьсан хөрөнгө оруулалт, хамтран хийхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжинэ гэдэгт би найдаж байна.

Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, ялангуяа эрдэс баялаг, түүхий эдийн салбарын хамтын ажиллагаанд томоохон түлхэц өгөх нэг алхам нь Налайх дүүрэгт байрлаж буй Монгол, Германы “Ашигт малтмал технологийн дээд сургууль”-г байгуулсан явдал юм. Тус сургуулийн үйл ажиллагаа жигдэрснээр герман боловсролтой монгол инженерүүдийн тоо огцом өсч, энэ салбарт бодит үр дүн гарна гэдэгт би итгэлтэй байна.

Эдийн засгийн харилцааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хоёр орны хувийн хэвшлийнхэн хамгийн чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд төр, засгийн зүгээс хууль, эрх зүйн тогтвортой орчныг илүү боловсронгуй болгож өгөх учиртай гэж би үздэг.

Аливаа хоёр орны хооронд явуулж буй харилцаа, хамтын ажиллагаа мэдээж харилцан ашигтай байх ёстой. Гэхдээ Монгол Улс шинэ тутам хөгжиж буй орны хувьд түншүүдээсээ дэмжлэг авч, энэ нь манай улсын хөгжлийг түргэтгэж, цаашид хоёр тал харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд томоохон түлхэц болох ёстой. Өөрөөр хэлбэл, энэ бүхэн манай хоёр орны харилцан ашигтай хамтын ажиллагааны суурь дэвсгэр болсоор ирсэн бөгөөд болсоор ч байх болно.

Хатагтай, ноёд оо,

Бид хамтын ажиллагааныхаа өнөөгийн түвшний тухай төдийгүй ирээдүйн хөгжлийн тухай бас зөвлөлдөн ярьдаг байх ёстой. Ирээдүй гэдэг ойлголт хязгааргүй үргэлжлэх орон зайг, тооцоолж хэмжихэд амаргүй зорилтыг, магадгүй зарим үед бүтэшгүй мэт санагдах мөрөөдлийг ч багтаан илэрхийлж байдаг. Өөдрөг зоримог хүсэл эрмэлзэлтэй, түүндээ бат итгэж, түүнийхээ төлөө хүчин зүтгэж чаддаг

*Эдийн засгийн
харилцааг
өргөжүүлэх,
хөрөнгө оруулалтыг
нэмэгдүүлэхэд
хоёр орны хувийн
хэвшлийнхэн хамгийн
чухал үүрэг гүйцэтгэх
бөгөөд төр, засгийн
зүгээс хууль, эрх зүйн
тогтвортой орчныг
илүү боловсронгуй
болгож өгөх учиртай
гэж би үздэг.*

Манай хоёр орны
хооронд он цагийн
бодит шалгуурыг
давсан харилцан
итгэлцэл, улс төрийн
харилцааны таатай
уур амьсгал, эдийн
засгийн хамтын
ажиллагааны
харилцан сонирхол,
түүнийг хэрэгжүүлэх
хүсэл зориг
бүрэн бий.

хүмүүсийн хувьд бол ирээдүй гэдэг үг хязгааргүй боломжийг илэрхийлдэг гэж би боддог юм. Тиймээс Монгол, Германы харилцааны ирээдүй бол өнөөдрийн бидний харилцааны хүрсэн түвшингээс, хүрэхээр тавьж буй алсын хараатай зорилтоос, түүнийг хэрэгжүүлэхийн төлөөх зориг эрмэлзэл, хамтын хүч чармайлтаас шууд хамаарна гэдэгт би итгэдэг. Энэ утгаар би Монгол, Германы харилцаа, хамтын ажиллагааны ирээдүйг гэрэл гэгээтэй, саруулхан бөгөөд өөдрөгөөр харж байна. Учир нь манай хоёр орны хооронд он цагийн бодит шалгуурыг давсан харилцан итгэлцэл, улс төрийн харилцааны таатай уур амьсгал, эдийн засгийн хамтын ажиллагааны харилцан сонирхол, түүнийг хэрэгжүүлэх хүсэл зориг бүрэн бий гэдэгт би итгэж байна.

Монгол, Герман улсын харилцааг цаашид илүү үр дүнтэй хөгжүүлэх ихээхэн боломж нөхцөл байна гэж үзэж байна.

- Харилцаа, хамтын ажиллагааны олон жилийн туршлагатай, эрх зүйн үндэс нь бүрдсэн. Герман Улс, герман хүний нэр хүнд манай улсад өндөр байдаг бөгөөд байгууллага, иргэдийн хооронд олон жилийн нөхөрсөг сайхан харилцаа тогтсон.

- Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжин орсноос хойш Монгол, Герман Улс ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, хуульт ёсыг дээдлэх нийтлэг нэгэн үнэт зүйлтэй болсон.

- Герман хэл, герман соёл эзэмшсэн олон мянган иргэн манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх гол тулгуур мөн. Өнөөдрийг хүртэл гучин мянган монгол залуус Герман Улсад боловсрол эзэмшин, герман хэл соёлыг нутагтаа түгээж, үүгээрээ Монгол, Германы харилцаанд хувь нэмрээ оруулж байна. Манай насанд хүрсэн хүн амын 1% орчим нь герман хэлний мэдлэгтэй байгаа нь Азийн орнууд дундаа тэргүүлэх үзүүлэлт юм.

- Эдийн засгийн салбарт хамтран ажиллах хоёр талын бодит сонирхол өсөн нэмэгдэж байна. Тухайлбал манай улс ашигт малтмалын ихээхэн нөөцтэй, Герман Улс нь түүнийг ашиглах байгалд ээлтэй өндөр технологитой байна.

- Иж бүрэн түншлэлийн хүрээнд манай хоёр орны харилцаа олон салбарт амжилттай хөгжиж байна. Энэхүү харилцааг илүү үр дүнтэй болгож идэвхжүүлэх талаар зарим нэг санал хэлье:

- Хоёр улсын улс төрийн харилцааны түвшинг хадгалан цаашид идэвхжүүлэх, иж бүрэн түншлэлийн хувьд хөгжиж буй хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, стратегийн түншлэлийн түвшинд хүргэх,

- ЕАБХАБ зэрэг олон улсын байгууллагын хүрээнд бие биенээ дэмжин хамтран ажиллах. 2016 оны долдугаар сард АСЕМ-ын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулахад ХБНГУ дэмжиж тусалсан бөгөөд Холбооны Канцлер Ангела Меркел биечлэн оролцсон нь үүний нэг илэрхийлэл мөн,

- Герман Улсад суралцаж герман хэл, соёл эзэмшсэн иргэдээ хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тодорхой бодлогын үндсэн дээр илүүтэйгээр татан оролцуулах,

- Хоёр талын батлан хамгаалах салбарын харилцааг, хамтын ажиллагаа, ялангуяа энхийг дэмжих олон улсын ажиллагааны хүрээнд амжилттай хөгжиж байгааг өргөжүүлэх,

- Улс төрийн түвшинд идэвхтэй хөгжиж буй хоёр талын

харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулах, зээл тусламжийн зэрэгцээ германы бодит оролцоо, сонирхлыг нэмэгдүүлэн харилцан ашигтай төсөл хэрэгжүүлэх,

- Уул уурхай болон эрчим хүчний салбарын төслүүдэд ХБНГУ-ын засгийн газрын хөгжлийн зээл авах, байгал орчны чиглэлд хэрэгжүүлж буй буцалтгүй тусламжийн төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх,

- ХБНГУ-аас Монгол Улсад үзүүлж буй хөгжлийн тусламжийн тэргүүлэх чиглэлд хүнс, хөдөө аж ахуйн салбарыг оруулах,

- Ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чиглэлээр Герман Улсын дэвшилтэт технологийг Монгол Улсад нутагшуулах, байгал орчинд ээлтэй орчин үеийн стандартуудыг нэвтрүүлэх, уул, уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн байгал орчны нөхөн сэргээлтийн тал дээр хамтран ажиллах,

- Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх, хөнгөн үйлдвэрийн салбарын кластерийн тогтолцоог хөгжүүлэхэд хамтран ажиллах,

- Манай улсын хөдөө аж ахуй хүнсний органик бүтээгдэхүүн, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн зэргийг Герман болон Европын холбооны зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортлох, бараа бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах,

- Жижиг дунд үйлдвэрийн салбарт инновацид суурилсан шинэ техник, технологи, өндөр үр ашигтай цогц үйлдвэрийн шинэ загвар шийдлүүдийг Монголд нутагшуулах, нэвтрүүлэх, энэ хүрээнд хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх,

Хатагтай, ноёд оо,

Монгол, ХБНГУ-ын парламент хоорондын харилцаа нь улс төрийн болон бусад бүх салбарт чухал үүрэгтэй. Манай хоёр орон парламентын засаглалтай билээ. 1991 онд Бундестагийн Дэд ерөнхийлөгч П.Ю.Кроненбэрг тэргүүтэй төлөөлөгчид анх айлчилснаас хойш өнгөрсөн хугацаанд парламент хоорондын харилцаа сайн хөгжиж ирлээ.

Ардчилсан хувьсгалын эхний өдрөөс эхлэн нийгэм тэр аяараа шинэ үзэл бодол, шинэ сэтгэлгээ, шинэ хандлагын сургалтын талбар болсон. Энэ үйл хэрэгт Конрад-Аденауер-Сан асар том үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал тус сан нь ардчиллыг хөгжүүлэх төслийн хүрээнд эрх зүйт төрийн байнгын ажиллагаатай парламентыг бэхжүүлэхэд зөвлөгөө өгөх Бундестагийн Тамгын газартай холбоо тогтоон, олон тооны мэргэжилтэнг Монголд урин ирүүлж онол практикийн бага хурал болон олон улсын бага хурал, зөвлөгөөнүүдийг зохион байгуулж ирсэн нь одоо ч үргэлжлэн явагдаж байна.

Мөн УИХ-ын гишүүдийг Герман болон дэлхийн бусад орнуудад зохион байгуулагддаг олон улсын томоохон чуулга уулзалтуудад оролцуулан туршлага судлуулах, Монгол Улсын ардчилсан хөгжлийн талаар үнэн зөв мэдээллийг дэлхий дахинд таниулан сурталчлах зорилготойгоор гадаад оронд ажиллуулах чиглэлээр олон ажил зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөөр байна.

Сүүлийн жилүүдэд тус сан Монгол Улсын сонгуулийн хуулийг боловсронгуй болгох нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх, тэр дундаа хөдөө орон нутаг дахь ИТХ-ын чадавхыг дээшлүүлэхэд түлхүү анхааран ажиллаж

Монгол, ХБНГУ-ын парламент хоорондын харилцаа нь улс төрийн болон бусад бүх салбарт чухал үүрэгтэй.

*Хоёр орны харилцаа,
хамтын ажиллагаа
бүхий л салбарыг
хамран хөгжиж
байгаатай уялдуулан
эрх зүйн салбарын
хамтын ажиллагааг
хөгжүүлэх, ингэхдээ
иргэний болон эрх
зүйн харилцан
туслалцаа үзүүлэх
тухай хэлэлцээр
байгуулах нь чухал
ач холбогдолтой
байна.*

байгаад бид талархаж байна.

Монгол Улс, ХБНГУ-ын харилцаанд парламент хоорондын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Миний бие 2016-2020 онд УИХ дахь Монгол-Германы парламентын бүлгийн даргаар үргэлжлүүлэн ажиллах болсондоо туйлын таатай буйн зэрэгцээ хоёр улсын парламентын найрамдлын бүлгүүд байнгын хороод, гишүүд, тамгын газрууд хоорондын хамтын ажиллагаа, үүгээр дамжуулан хоёр улсын харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд өөрийн зүгээс хүчин чармайлт гарган дэмжлэг үзүүлж ажиллахаа илэрхийлэхийг хүсч байна. Сүүлийн жилүүдэд УИХ дахь Монгол-Германы парламентын бүлэг Бундестаг дахь Төв Азийн бүлгийн гишүүдийн харилцан айлчлал тогтмолжиж, гишүүд хоорондоо хэлхээ холбоогоо зузаатгаж байна. Хууль тогтоох байгууллагуудын харилцаанд Германы Бундестагийн зүгээс өндөр ач холбогдол өгч анхаарал хандуулж байгааг мөн энд онцлон дурдах нь зүйтэй.

Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарыг хамран хөгжиж байгаатай уялдуулан эрх зүйн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, ингэхдээ иргэний болон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хэлэлцээр байгуулах нь чухал ач холбогдолтой байна. Хоёр орны иргэд албан паспортоор харилцан визгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх нь иргэд харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчилж, энэ нь цаашлаад хоёр улсын иргэд, бизнес эрхлэгчид хоорондын хэлхээ холбоог сайжруулахад нэн чухал алхам болох юм. Монгол-Германы харилцаа, хамтын ажиллагаа цаашид өргөжин бэхжинэ гэдэгт миний бие итгэл төгс байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Дэндэвийн Тэрбишдагва

*МУ-ын УИХ-ын гишүүн,
Монгол-Германы парламентын бүлгийн дарга*

ХБНГУ-ЫН УЛС ТӨР ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮД – ӨНГӨРСӨН БА ОДОО ЦАГТ

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

"Юуг ч шаарддаггүй эмэгтэйчүүд юуг ч олж авдаггүй."

Францын нэрт зохиолч, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгч, Симон де Бувуарын хэлсэн энэ үг зөвхөн Франц эсвэл Герман оронд биш, мөн Монголд ч нэгэн адил тохирох юм.

Миний бие энэ удаагийн Монгол-Германы Чуулганаар "ХБНГУ-ын улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд" сэдвийн хүрээнд илтгэл сонордуулах урилгыг дуртайяа хүлээж авсан.

Эмэгтэйчүүд хоорондоо туршлага солилцож байх ёстой мөн бид хоорондоо эв нэгдэлтэй байх учиртай гэдэгт миний бие бат итгэдэг. Бид юун түрүүнд улс дотроо энэ хандлагыг бий болгох хэрэгтэй ба цаашлаад эл хандлагад хил хязгаар байх ёсгүй тул дэлхий даяараа дагаж мөрдөх хэрэгтэй. Тийм ч учраас эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах нь энд сууж буй ноён Даниел Шмюкингийн төлөөлж байгаа мөн бас миний харьяалагддаг Конрад-Аденауэр-Сангийн нэгэн чухал зорилт юм.

Конрад-Аденауэр-Сангийн үйл ажиллагааны хүрээнд бид "Эмэгтэйчүүдгүйгээр төр улсыг цогцлоох аргагүй" гэдгийг онцолдог. Гэвч энэ хандлагыг төлөвшүүлэх зам урт бөгөөд амаргүй байсан.

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо,

Миний бие та бүхэнтэй 30 минутын богино аялал хийх илтгэлийг бэлтгэж ирсэн.

1. Цаг хугацааны аялал. Герман Улсад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд адил тэгш эрхтэй амьдрах үндсэн суурийг бий болгохын тулд ямар алхмууд шаардлагатай байсан бэ?
2. Хоёр дох зогсоол: Миний хувийн замнал. Эмэгтэй хүний хувьд улс төрд хүчин зүтгэх замнал маань ямар байсан бэ?
3. Гурав дахь зогсоол: Өнөө үе. Улс төрийн салбарт ажиллаж буй өнөөгийн эмэгтэйчүүдийн нөхцөл байдал ямар байна вэ? 21 дүгээр зууны хоёрдугаар 10 жилд бид ямар түвшинд хүрэв?
4. Хурдны галт тэрэг доторх уралдаан барианд хүргэхгүй. Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдэд зөвхөн эмэгтэйчүүдийн асуудлын хүрээнд бодлого боловсруулахаас гадна, улс төрийн бүхий л салбарын шийдвэр гаргалтанд нөлөөлөх ямар нөөц бололцоо бий вэ?
5. Ирээдүйд хүрэх зам. Шийдэлд нь эмэгтэйчүүдийн оролцоо онцгой шаардлагатай асуудлуудын талаарх миний бодол.

1. Цаг хугацааны аялал.

Герман Улсад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд адил тэгш эрхтэй



*"Эмэгтэйчүүдгүйгээр
төр улсыг цогцлоох
аргагүй"*

20 дугаар зуун
тэр чигтээ
эмэгтэйчүүдийн
эрхийн төлөөх
эмэгтэйчүүдийн
тэмцлээр дүүрэн
байв. Тэд асар их
саад бэрхшээлийг
туулж байж ижил
тэгш эрхийг алхам
алхмаар олж авч
чадсан юм.

амьдрах үндсэн суурийг бий болгохын тулд ямар алхмууд шаардлагатай байсан бэ?

Герман оронд бусад улс орнуудаас өөр байсангүй. 20 дугаар зуун тэр чигтээ эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх эмэгтэйчүүдийн тэмцлээр дүүрэн байв. Тэд асар их саад бэрхшээлийг туулж байж ижил тэгш эрхийг алхам алхмаар олж авч чадсан юм.

Эмэгтэйчүүд эрхийнхээ төлөөх тэмцлийг сонгуулийн эрхийн төлөөх тэмцлээр эхлүүлсэн. 1918 оны арваннэгдүгээр сарын 12-ны өдрийн тэмцлийн үр дүнд 1919 оны нэгдүгээр сард болсон хууль тогтоох Үндэсний Их Хурлын шийдвэрийн дагуу эмэгтэйчүүд сонгох, сонгогдох эрхтэй болсон. Энэ нь Германы Хаант Улсын төгсгөл үе буюу дэлхийн I дайнд ялагдсаны дараах үе байлаа. Уг сонгуулийн уриалгад "Олон нийтийн бүх сонгуулийг одооноос нийтэд нээлттэй, тэгш, шууд байдлаар явуулах бөгөөд нууцаар санал хураах зарчмын дагуу 20 нас хүрсэн бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүс сонгуульд оролцох эрхтэй" гэсэн байдаг.

Сонгогдсон Үндэсний Их Хурлаар Ваймарын Үндсэн хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 109-р зүйлд "Бүх германчууд хуулийн өмнө ижил тэгш эрхтэй. Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд зарчмын хувьд адил тэгш иргэний эрх, үүрэгтэй байна" хэмээн зааж эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг иргэний хувьд ижил тэгш эрхтэй болгосон байна.

Ваймарын Бүгд Найрамдах Улсын олон чухал хууль эмэгтэйчүүдийн санаачилгаар батлагдсан байдаг. Тэдгээрээс онцолбол:

1922 оны Эмэгтэйчүүдийн шүүхийн төлөөлөгч, сайн дурын шүүгч, шүүгчээр сонгогдох эрхийн тухай хууль

1922 оны Гэрээр хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийг нийгмийн даатгалд хамруулах тухай хууль

1927 оны Жирэмсэн болон нялх хүүхэдтэй эхийг хамгаалах тухай хууль

Дэлхийн II дайны дараа Баруун Германы Үндсэн хуулийг батлах үеэр "Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд тэгш эрхтэй" гэсэн сонсоход тун энгийн өгүүлбэрийг тусгах гэж хүчтэй маргаан өрнөсөн байна.

Улмаар Парламентын зөвлөлийн 4 эмэгтэй гишүүн болох Хелене Вессел (Төв/Христийн Ардчилсан Нам), Хелене Вебер (Христийн Ардчилсан Нам), Фридерике Надиг (Германы Социалдемократ Нам) болон Элизабет Селберт (Германы Социалдемократ Нам) нар үндсэн хуулийг боловсруулах үйл явцад нам харгалзалгүй хамтран ажилласны үр дүнд энэхүү энгийн өгүүлбэрийг Үндсэн хуулинд оруулан батлуулж чадсан байдаг.

1957 онд анхны Тэгш Эрхийн тухай хууль батлагдав.

Герман Улс эргэн нэгдсэнийхээ дараа Үндсэн хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулж, уг өөрчлөлтөөр эмэгтэйчүүдийг идэвхтэй дэмжих тухай Үндсэн хуулинд тусгаж, албан ёсны нэг заалт болсон. Ингэснээр төр эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн тэгш эрхийг бодитойгоор хангаж, тэгш бүс байдлыг арилгах үүрэг хүлээсэн юм.

1994 онд тэгш эрхийн тухай хоёр дахь хууль батлагдсан. Уг хуулинд ажил мэргэжил болон гэр бүлийг илүү сайн хослуулах явдлыг дэмжих, удирдах албан тушаалтнуудын хагас цагаар ажиллах эрх, удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийг идэвхтэй дэмжих, түүнчлэн ажилд орох, чадвар эзэмших, албан тушаал ахих болон мэргэжил дээшлүүлэх зэрэгт эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг адил тэгш боломжоор хангах зэрэг заалтууд тусгагдсан байна.

Үүнээс хойш эмэгтэйчүүдийг дэмжих төлөвлөгөө, жишиг төслүүд болон өөр бусад олон тооны хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

90-ээд оны дунд үе гэхэд эмэгтэйчүүдийг дэмжих идэвхтэй бодлого нь улс төрийн салбарт бодит биеллээ олж чадсан гэж хэлж болно. Үүнийг улс төр дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь болон эмэгтэй гишүүдийн тооноос харж болно. Мөн маш олон тооны нийгмийн болон гэр бүлийн бодлогын арга хэмжээг, тухайлбал аавуудад хүүхдээ асрахад нь зориулагдсан эцгийн амралтыг бий болгосон мөн хүүхэд төрсөн эхний өдрөөс эхлэн хүүхдийг ясли цэцэрлэгт өгөх эрхийг холбооны улс даяар нэвтрүүлж чадсан зэрэг нь үүний илрэл юм. Түүнчлэн хөгшин настай, асрамж шаардлагатай хүмүүст зориулагдсан гэр бүлийг дэмжих хөтөлбөрүүд мөн эмэгтэйчүүдийн тэтгэврийн эрхийг эрс сайжруулсан зэрэг нь ч үүнд хамаарна. 2000 оны дунд үед өрнөсөн эмэгтэйчүүдийн болон гэр бүлийн бодлогын талаарх мэтгэлцээнүүд жинхэнэ эргэлт хийж чадсан. Манай өнөөгийн Батлан хамгаалах яамны сайд Урсула фон дер Лайен тухайн үед Эмэгтэйчүүдийн болон Гэр бүлийн яамны сайд байсан бөгөөд тэрээр эмэгтэйчүүдийн олон асуудлыг маш их хүчин чармайлт гарган шийдвэрлэж чадсан юм.

Эцэст нь нэмж хэлэхэд др. Ангела Меркел 2005 оноос хойш Германы канцлерын албыг чадварлагаар хашиж, дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдөж байгаагаар бид бахархдаг.

2. Хоёр дахь зогсоол: Миний хувийн замнал.

Энд би цөөхөн хэдэн зүйлийг дурдмаар байна:

Миний улс төрд орсон үе бол 1989/1990 оны хооронд БНАГУ-д болсон тайван хувьсгалын үе байлаа. Уг хувьсгалд миний бие Христосын Ардчилсан Намыг төлөөлөн идэвхтэй оролцсон юм.

Би 1990 онд дахин байгуулагдсан Тюринген муж улсын Боловсролын сайдаар томилогдсноор тухайн засгийн газар дахь цорын ганц эмэгтэй нь болсон юм. 1999 онд миний бие Парламентын Ерөнхийлөгчөөр сонгогдсон бөгөөд анх удаа дан эмэгтэйчүүдээс бүрдсэн, тэд нь гурван өөр намд харьяалагддаг, парламентын удирдах зөвлөлийг байгуулсан. Энэ нь улс төрийн хүрээнд тун сонирхолтой үйл явдал байлаа. 2009 онд би Христосын Ардчилсан Нам болон шинэ холбооны улсуудын хувьд мужийн анхны эмэгтэй Ерөнхий сайд болсон. Одоо бол Герман Улсад 3 эмэгтэй Ерөнхий сайд байна. Үүнээс гадна миний бие 2009-2014 онд Тюринген муж улсын Христосын Ардчилсан Намын даргаар ажиллаж байлаа. Би 25 жилийн турш улс төрийн алба хашихдаа үргэлж ажил мэргэжил болон гэр бүлээ хослуулан авч явсаар ирсэн. Би нөхөртэй, хоёр хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд одоо эмэг эх болсон.

*90-ээд оны дунд үе
гэхэд эмэгтэйчүүдийг
дэмжих идэвхтэй
бодлого нь улс
төрийн салбарт бодит
биеллээ олж чадсан
гэж хэлж болно.
Үүнийг улс төр дэх
эмэгтэйчүүдийн эзлэх
хувь болон эмэгтэй
гишүүдийн тооноос
харж болно.*

Улс төрийн шийдвэр
гаргах түвшин дэх
эмэгтэйчүүд олширч
байгаа нь нэгэнт
эргэлт буцалтгүй чиг
хандлага болжээ.
Улс төрийн
зөвлөлүүдийн,
ялангуяа
парламентуудын доод
тал нь гуравны нэгийг
эмэгтэйчүүд бүрдүүлж
байна. Одоо эдийн
засгийн салбарт энэ
хандлага ажиглагдаж
эхэлж байна.

3. Гурав дахь зогсоол: Өнөө үе
21-р зууны хоёр дахь 10 жилд Германд ямар түвшинд хүрэв?
Би нэг л зүйлийг баттай хэлж чадна: Эмэгтэйчүүд өнөөг
хүртэл өөрсдийн замаар, заримдаа ухарсан ч цөхрөлтгүй
урагшилсаар байна. Ирээдүйд ч тэгэх болно.

Нэн ялангуяа улс төрд буй эмэгтэйчүүд бусад
эмэгтэйчүүдийнхээ төлөө хүчин зүтгэсээр байна. Герман
Улсын төрийн тэргүүнээр Холбооны Канцлер др. Ангела
Меркел буюу эмэгтэй хүн ажиллаж байна. Германы Батлан
хамгаалахын сайд эмэгтэй хүн байна. Түүнчлэн холбооны
улсын засгийн газарт буюу Байгаль орчин ба Барилгын яам,
Гэр бүл ба Залуучуудын яам, Хөдөлмөрийн яамд эмэгтэй
сайдтай бөгөөд Соёл ба хэвлэл мэдээллийн салбарыг ч
эмэгтэйчүүд хариуцан ажиллаж байна. Үүнээс гадна олон
салбарын төрийн нарийн бичгийн дарга нар эмэгтэй хүмүүс
байна, тухайлбал Гадаад явдлын яамны проф. др. Мариа
Бомер. Тюринген муж улсын засгийн газрын 10 хүний
тав нь буюу хагас нь эмэгтэйчүүд. Холбооны муж улсын
түвшний зарим танхимуудад, жишээлбэл Райнланд-Пфалц
муж улсад, эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээсээ ч олон байна.
Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд олширч
байгаа нь нэгэнт эргэлт буцалтгүй чиг хандлага болжээ. Улс
төрийн зөвлөлүүдийн, ялангуяа парламентуудын доод тал
нь гуравны нэгийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Одоо эдийн
засгийн салбарт энэ хандлага ажиглагдаж эхэлж байна.
Томоохон компаниудын удирдах зөвлөлийн гуравны нэгийг
ирээдүйд мөн эмэгтэйчүүд бүрдүүлэх хэрэгтэй. Гэхдээ
бидэнд улс төр, эдийн засгийн шийдвэр гаргах түвшин дэх
эмэгтэйчүүдийг нэмэгдүүлэхэд саад бэрхшээл олон байна.
Улс төр, эдийн засгийн карьерт бүрэн тохирох, боловсрол
сайтай эмэгтэй бүр карьертай холбоотой өдөр тутмын
зөрчилдөөнд сайн дураараа орооцолдохыг хүсдэггүй. Өөр
нэг нэмэлт мэдээллийг товчхон танилцуулъя: Германы
гимнази төгсөгчдийн 55% нь охид бөгөөд тэд хөвгүүдээс
илүү олноороо их дээд сургуульд элсэн суралцаж, боловсрол
эзэмших эрхээ эдэлж байна. Их дээд сургуулийн эхний
семестрүүдэд мөн л илүү олон охид байна. Харин дараа нь
байдал эсрэгээрээ эргэчихдэг. Бид удирдах зөвлөлүүдийн
30%-ийг бүрдүүлэх квотод хүрэхийг эрмэлздэг боловч
яг одоогоор эдийн засгийн салбарын удирдах албан
тушаалтнуудын ердөө 11% нь л эмэгтэйчүүд байна. Шинжлэх
ухааны профессоруудын дундах эмэгтэйчүүдийн тоо ч мөн
үүнээс ихгүй. Гар урлалын салбарын нийт мастеруудын
12% нь л эмэгтэйчүүд байна.

Манай орны эмэгтэйчүүдийн бодлого хангалттай хэрэгжиж
чадахгүй байгаагийн илрэл энэ мөн үү? Эсвэл эрчүүд эдгээр
салбарын эмэгтэйчүүдээс илүү амжилттай байгаад учир нь
байна уу? Эсвэл өнөөгийн карьерын хэв маягт эмэгтэйчүүд
дасан зохицох хүсэлгүй, дасан зохицож чадахгүй эсвэл бүр
дасан зохицох ёсгүй юм болов уу? (чухам эдгээрийн аль
нь гэдгийг ярилцаж тогтоох хэрэгтэй байх) Үүнээс миний
хөндөх дараагийн асуудал урган гарч байна: улс төрийн
шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн чанарын
боломжийн тухай асуудал.

4. Хурдны галт тэрэг доторх уралдаан барианд хүргэхгүй.
Зөвхөн эмэгтэйчүүдийн бодлогын салбарт бус, бүхий л
салбарт улс төрийн шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй
эмэгтэйчүүдтэй холбоотой чанарын боломж гэж юуг хэлж

байна вэ? Хэтэрхий олон шинжит 21 дүгээр зууны онцлогийг харъя. Уян хатан чанар, хөрвөх чадвар, байнгын бэлэн байдал нь эдийн засгаас гадна олон хүний хувийн амьдралын шинж чанарыг тодорхойлж байна. Олон хэлтэй залуу элитүүдийг хар. Тэд өдөрт 24 цагийн турш интернэтээр дэлхийг тойроод зогсохгүй, бодит байдал дээр өглөө нь Лондонд, орой нь Нью-Йоркд, дараагийн өдөр нь Токиод, эцэст нь Шинэ-Дели хотод уулзалтад оролцож байна. Эдний дунд зөвхөн эрчүүд биш, цөөн тооны эмэгтэйчүүд ч бас байна. Гэхдээ зөвхөн элитүүд биш, өнөө цагт харилцаа холбоо, мэдээллийн өндөр хурдны сүлжээ байсаар байхад энгийн нэгэн бизнес эрхлэгч ч ажил мэргэжлийн шаардлагаар нааш цааш байнга зорчиж байна. Бид эдийн засаг, харилцаа холбооны асар хурдтай амьдралыг туулан өнгөрүүлж байна. Энэ нь эмэгтэйчүүдэд, нэн түрүүнд гэр бүлд тийм ч ээлтэй зүйл биш юм. Зөвхөн төрөлтийн хэмжээг ажиглахад л үүний сөрөг нөлөөг ажиглаж болно. Тийм учраас миний бодлоор улам хурдтайгаар эргэлдэж байгаа энэ морин тойруулган тоглоомонд хамт эргэлдэх гэж улам олон эмэгтэйчүүдийг зүтгүүлэх нь бидний зорилго байж таарахгүй. Ингэх нь дэндүү өрөөсгөл бөгөөд миний бодлоор хэт хоцрогдсон арга юм. Фридрих Энгельс нэгэнтээ: "Эмэгтэйчүүд нийт нийгмийн хэмжээнд үйлдвэрлэлд оролцож, гэрийн ажил тэдний цагаас маш бага хэмжээгээр хомсолдог болсон цагт л эмэгтэй хүн чөлөөтэй болох боломжтой" гэсэн байдаг.

Үгүй ээ! Өнөөдөр 150 жилийн дараа бид зорилгоо бүр илүү нарийвчлан тодорхойлох ёстой. Өнөөдөр бид тэр морин тойруулган тоглоомын бүтцийг өөрчлөх ёстой. Хэрэв бид түүнийг өөрчлөлгүй орхиж, өөрсдөө түүнд нь дасан зохицох гэж хичээх юм бол маш ихийг алдах болно. Ингэхдээ "бид" гэдэг тодотголыг урдаа барих ёстой. Хүүхэд төрүүлж, гэр бүлтэй болох нь зөвхөн хэсэг эмэгтэйчүүдийн бус нийт нийгэм буюу "бидний" хүсэл гэдгийг цагийн аясаар улам хөгширч буй нийгмээ хараад дүгнэж болохоор байна. Хүүхэдгүй нийгэмд ямар ч ирээдүй үгүй.

Тиймээс эмэгтэйчүүдэд хүүхэд, гэр бүлээ карьертайгаа хослуулах чөлөөт орон зайг бий болгох хэрэгтэй. Иймдээ ч тэдний хувьд хувийн чөлөөт орон зай ба уян хатан ажлын цагийг чухалчилж үзэх нь эрчүүдээс 3 дахин илүү байдаг. Иймд зөвхөн хүүхдүүд болон гэр бүлийн ашиг сонирхлын үүднээс бус нийт нийгмийн ашиг сонирхлын үүднээс үүнийг харгалзаж үзэх ёстой. Нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт байгаа эмэгтэйчүүдийг төлөөлж үүнийг улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд шийдвэрлэхийн тулд төлөөлөн ажиллах нь хамгийн тохиромжтой. Гэр бүлийн өдөр тутмын амьдралаас эхлээд бидний нийгмийн харилцаа бүгд "эдийн засагжсан" нь зөвхөн эмэгтэй хүний байгалын шинж чанарт бус бидэнд бүгдэд нь хор хөнөөлтэй байна. Энэ нийгмийн тогтолцоо мөн хүүхдэд маш халтай. Ихэнх тохиолдолд энэ нь хувь хүний өөрийн сонгох байсан амьдралын замтай нь зөрчилддөг. Үүнээс үүдсэн асуудлууд биднийг урьд хожид байгаагүй хүн ам зүйн хөгжлийн асуудалд хүргэж байна. (Энэ нь өөр нэг бүтэн илтгэл болохоор сэдэв юм.)

Улс төр дэх эмэгтэйчүүд бусад эмэгтэйчүүдийн байгууллагуудтайгаа хамтарснаар энэхүү цэвэр эдийн засагжсан, тэр хэмжээгээрээ бас ардчилал багатай бүтцийг эвдэж чадна. Энэ тэмцэлд би энд суугаа бүх хүмүүсийг

Хүүхэд төрүүлж,
гэр бүлтэй болох
нь зөвхөн хэсэг
эмэгтэйчүүдийн бус
нийт нийгэм буюу
"бидний" хүсэл
гэдгийг цагийн
аясаар улам хөгширч
буй нийгмээ хараад
дүгнэж болохоор
байна. Хүүхэдгүй
нийгэмд ямар ч
ирээдүй үгүй.

Тиймээс
эмэгтэйчүүдэд
хүүхэд, гэр бүлээ
карьертайгаа
хослуулах чөлөөт
орон зайг бий болгох
хэрэгтэй.

Гэр бүлийн өдөр
тутмын амьдралаас
эхлээд бидний
нийгмийн харилцаа
бүгд "эдийн
засагжсан" нь
зөвхөн эмэгтэй
хүний байгалын
шинж чанарт бус
бидэнд бүгдэд нь хор
хөнөөлтэй байна.

онцлон уриалж байна!

5. Ирээдүйд хүрэх зам.

Шийдэлд нь эмэгтэйчүүдийн оролцоо онцгой шаардлагатай асуудлуудын талаарх миний бодол. Энэ асуудал хүүхэд болон гэр бүлд ээлтэй, улмаар илүү гэгээлэг ирээдүйтэй дэлхийг бий болгох үндсэн зорилтод хүрэх суурь нь юм. Би гуравхан жишээ дурдъя.

1. Суралцах хугацаа

2. Гэр бүл зохиох болон анхны хүүхэд төрөх үе (1 дүгээр сэдвийн өөр нэгэн хувилбар)

3. Залуу эмэгтэйчүүдийн ажил мэргэжлийн сонголт

Эхний жишээ:

Олон жилийн өмнөөс, хуучин БНАГУ ХБНГУ-д нэгдэн орсноос хойш сурах хугацааг богиносгох шаардлагын тухай яригдсаар ирлээ. 1981 оноос хойш их дээд сургууль төгсөгчдийн дундаж нас 2-3 жилээр нэмэгдэж, одоо 29 болсон байна. Олон улстай харьцуулахад энэ бол түгшүүр зарласан тоо юм.

Үүн дээр дадлагын хугацаа, албан тушаал горилох хугацаа болон бусад хугацаа нэмэгдэнэ. Энэ маягийн хөгжлийн үйл явцаас болоод бид эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрүүд болон бусад төслүүдээ мартаж хэрэгтэй болох нь. Залуу хүмүүсийг тэдний амьдралын хамгийн бүтээлч үе нь болох 20-30 насанд нь их дээд сургуулийн хүнд суртлаар булаах нь бидний улс төрийн зорилго байж таарахгүй. Энэ хэв маяг залуу хүмүүсийн амьдралынхаа хамгийн чухал үед бие дааж амьдрах боломжийг нь үгүй хийж байна.

Эхлээд сургууль төгсөж мэргэжил эзэмшээд, дараа нь хүүхэд болон гэр бүлтэй болно гэсэн ухаалаг уриаг дагаж байгаа хүнд сүүлийнхийг нь биелүүлэх боломж бараг байхгүй. Эмэгтэй хүний хувьд 30-аад насныхаа эхний хагаст хүүхдээ гаргаж хүүхэд нь сургуульд орчихвол карьер хөөх боломж гарч магадгүй юм. Дараа нь бол хэцүү! Үүний эсрэг бид улс төрийн тэмцэл хийх хэрэгтэй. Энэ асуудлын гол хохирогчид эмэгтэйчүүд болохын хувьд бидэнд зорьсондоо хүрэх чадал хэрэгтэй байна.

Хоёрдугаар жишээ - эхний сэдвийн өөр нэгэн хувилбар: Холбооны Улсын Статистикийн Албаны мэдээнд: "90-ээд оны эхээр гэрлэж байгаа эмэгтэйчүүдийн дундаж нас 26 байсан бол одоо 30-аас доош насанд бараг гэрлэхээ больжээ" гэсэн байна. Үүний шалтгааныг шинжлэх ухааны үүднээс судалж үзээд "илүү их сурч боловсрох дарамт нь эмэгтэйчүүдийг гэр бүлийн талаар оройтож бодоход хүргэж байна" гэжээ.

Тийм ч учраас төрөхөд хамгийн тохиромжтой 18-25 насанд үр хөндүүлэх явдал онцгой их байна. Эмэгтэйчүүд болон гэр бүлийг дэмжих талаар урьд хожид байгаагүй ихээр ярьж байгаа энэ үед ийм зүйл тохиолдож байгаа нь харамсалтай хэрэг. Манай нийгэмд хүн ам зүйн аюул нүүрлэж байгаа энэ цаг үед эмэгтэйчүүд, гэр бүлд тустай радикал өөрчлөлт хийгээд ч нэгэнт эргэлт буцалтгүй үүсчихсэн байгаа хор хохирлыг зогсоох аргагүй, сайндаа бага зэрэг багасгаж л чадна гэдгийг бид бүгд ойлгосон байх. Энд ч мөн эмэгтэйчүүд гол хохирогч нь болж буйнхаа хувьд хөдлөх хэрэгтэй байна. Нэг боловсролын журмыг нөгөөх дээр нь хавсарсаар

эцэст нь гэр бүл зохиох болон хүүхэд төрүүлэх байгалын жамыг хөсөр хаяж буй нь бидний зорилго байж таарахгүй.

Гуравдугаар жишээ:

Эцэст нь би олон охидын өсч, дэвжих боломжоо үгүй хийж байгаа мэргэжил сонголтын асуудлыг дурдмаар байна. Мэргэжлийн сургалтанд хамрагдаж байгаа охидын 83% нь боломжит 360 гаруй мэргэжлийн 25 орчим дээр нь л төвлөрдөг. Тэдгээр нь голцуу анх ажилд ороход болон цааш дэвших боломж муутай үйлчилгээний салбарын мэргэжлүүд байдаг. Энэ нь их дээд сургуулиуд дээр мөн давтагддаг. Эмэгтэй оюутнууд хүмүүнлэгийн ухааны факультетэд олон байхаас биш эдийн засаг, инженерийн факультетуудад цөөхөн байдаг.

Энэ чиг хандлага орчин үеийн, шинээр гарч ирж буй мэргэжлүүд дээр бүр санаа зовоохоор байна. Дижитал хэвлэл мэдээллийн дизайнер, АйТи-систем электроник, Эвент-техникийн мэргэжилтэн, микротехнологич эсвэл мехатроникч зэрэг орчин үеийн мэргэжлүүдээр төгсөгчдийн ердөө 38% нь л эмэгтэйчүүд байна. Эдгээр орчин үеийн мэргэжлүүд үйлдвэрлэл-техникийн мэргэжлүүдтэй нэгэн адил зөвхөн залуу эрчүүдийн салбар болж хувирбал юутай харамсалтай вэ.

Эрхэм ноёд хатагтай нараа,

Дээрх жишээнүүд агуу зорилгын цаана ямар их ажил бийг мөн эмэгтэйчүүдийн амьдралын болон ажлын тодорхой нөхцлүүдийн талаар ямар их эргэцүүлэх зүйл бидэнд байгааг харуулж байна.

Гэхдээ энэ хүрээнд зөвхөн эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх уламжлалт тэмцэл биш өөр олон асуудлын тухай яригдаж байна. Өнөөдөр бид нийт нийгмийн сайн сайхан ирээдүйг хэрхэн бүтээх талаар ярьж байна. Тийм ирээдүйг бид эмэгтэйчүүд эрчүүдийг дуурайх гэж оролдох шаардлагагүй, харин эмэгтэйчүүдийн амьдралын хэрэгцээ, туршлага болон шаардлагыг хангасан тийм хүчтэй ардчиллыг бий болгосон цагт л бүтээж чадна. Эмэгтэйчүүдийг сонсдог, эмэгтэйчүүд нь олонх болж чаддаг болсон цагт л эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд хамтдаа сайн сайхан ирээдүйг бүтээж чадна.

Кристине Лийберкнехт

*ХБНГУ-ын Тюринген муж улсын Ерөнхий сайд асан,
Тюринген муж улсын Ландтагийн гишүүн*

*Өнөөдөр бид нийт
нийгмийн сайн сайхан
ирээдүйг хэрхэн
бүтээх талаар ярьж
байна. Тийм ирээдүйг
бид эмэгтэйчүүд
эрчүүдийг дуурайх
гэж оролдох
шаардлагагүй, харин
эмэгтэйчүүдийн
амьдралын хэрэгцээ,
туршлага болон
шаардлагыг
хангасан тийм
хүчтэй ардчиллыг
бий болгосон цагт л
бүтээж чадна.*

МОНГОЛ УЛС ДАХЬ АРДЧИЛЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨР ДЭХ ОРОЛЦОО

Эрхэмсэг хатагтай, ноёд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая!



"Та өөртөө ямар нэг юм хэлүүлэхийг хүсвэл эрэгтэй хүнийг дууд, харин ямар нэг юм хийлгэхийг хүсвэл эмэгтэй хүнийг дууд" Маргарет Тетчер.

Монгол Улс ардчиллын чиг баримжааг сонгосон цагаас эхлэн УИХ-ын 7 удаа, орон нутгийн сонгууль болон ерөнхийлөгчийн сонгуулийг 6 удаа амжилттай зохион байгуулаад байна. Үүний хамтаар эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ТББ-ууд, олон улсын байгууллагууд болон Монгол Улсын Төр, Засгийн газрын зүгээс улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар бага бус хүчин чармайлтыг тавин ажиллаж байгааг хэлэх нь зүйтэй юм.

Гэвч аливаа улсын жендэрийн эрх тэгш байдлын биелэлтийг хэмжих гол шалгуураар парламентад суух эмэгтэйчүүдийн хувь байхаар зааж, энэхүү үзүүлэлтийг 30 хувьд хүргэх зорилт тавьсан байдаг. 30 хувийн квотод хүрсэн улсын тоо 1995 онд тав байсан бол 2015 онд 43 болж нэмэгдсэн төдийгүй парламентад суух эмэгтэйчүүдийн эзлэх хувь 11.3-22.1 хувьд хүрсэн ч ахиц дэвшил улс орнуудад жигд явагдахгүй байгаа судалгааг гаргажээ. Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд улс орнууд төрөл бүрийн стратеги боловсруулж, квот хуульчилсан улсад нийт суудлын 25 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Манай улсад 2016 оны 3 дугаар сард 2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо 11 байсан бөгөөд энэхүү үзүүлэлтээрээ дэлхийд 95-д жагсаж байв. Харин 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр 13 эмэгтэй гишүүн сонгогдсон нь парламентын гишүүдийн 17 хувийг эзэлж байгаа.

Монгол Улс нь Үндсэн хууль болон бусад салбар хуулиуд, үндэсний хэмжээний хөтөлбөрүүд зэрэг баримт бичгүүдэд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангах талаар тодорхой алхамуудыг авч чадсан. Мөн НҮБ болон олон улсын гэрээ хэлэлцээрээр шаардлагатай үүргүүдийг өөртөө хүлээсэн билээ.

Би өөрийнхөө энэхүү илтгэлийн хүрээнд 1 дүгээрт Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд, эрх зүйн орчны талаарх мэдээллийг та бүхэнд товч хүргэх, 2 дугаарт өнөөгийн нийгэм сэтгэл зүйн нөхцөл байдлын талаарх бодит нөхцөл байдлыг судалгааны үндсэн дээр тайлбарлахыг хичээх болно.

1. Эрх зүйн орчин, төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд.

*Манай улсад
2016 оны 3 дугаар
сард 2012 оны
УИХ-ын сонгуулийн
үр дүнгээр сонгогдсон
эмэгтэй гишүүдийн
тоо 11 байсан бөгөөд
энэхүү үзүүлэлтээрээ
дэлхийд 95-д жагсаж
байв. Харин 2016 оны
УИХ-ын сонгуулийн
үр дүнгээр 13 эмэгтэй
гишүүн сонгогдсон
нь парламентын
гишүүдийн 17 хувийг
эзэлж байгаа.*

1.1. Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалт Монгол Улс олон улсын хүний эрхийн суурь зарчим, стандартуудыг хангахыг бүрэн дэмждэг бөгөөд эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилт бүхий дараах олон улсын гэрээ, хэлцлүүдэд гарын үсэг зурж, нэгдэн орсон билээ.Үүнд:
 -Хүний эрхийн түгээмэл тунхаглал
 -Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
 -Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
 -Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц
 -Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц
 -Хөдөөгийн эмэгтэйчүүдийн орчин нөхцөлийг дээшлүүлэх тухай конвенц
 -Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд алагчлахгүй байх тухай ОУХБ-ын конвенц
 -Боловсролын салбар дахь алагчлах үзлийн эсрэг конвенц
 -Амаржсан эхийн эрхийг хамгаалах ОУХБ-ын 103 дугаар конвенц
 -Тэгш шан, хөлс олгох тухай ОУХБ-ын конвенц

1.2. Монгол Улсын Үндсэн Хууль (1992)

1924 онд батлагдсан Монгол Улсын анхны Үндсэн хуульд эрэгтэй, эмэгтэйчүүд улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд яс үндэс, хүйс, шашин шүтлэг, хөрөнгө чинээг харгалзахгүйгээр тэгш эрхтэй оролцоно гэж тунхагласан байдаг.

1990 оноос хийгдсэн нийгмийн шинэчлэлтэй холбогдуулан эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах талаар илүүтэй анхаарах болсон бөгөөд 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль хүйсийн тэнцвэрт байдлыг хангах тухай заасан байдаг (МСС-ХБОНУЗБ 2011, 6). Үндсэн хуулийн 16-р зүйлд: “Эрэгтэй эмэгтэй хүмүүс нь гэр бүлийн дотор ба соёл, нийгэм, эдийн засгийн болон улс төрийн хувьд ижил тэгш эрхтэй байна гэж заасан байдаг Үндсэн хуулийн 16-р зүйлд: Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заажээ.

1.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)
 Энэхүү хуулиар улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн үндэс бүрдэж байгаа бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангах, энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хүлээх хариуцлагыг тодорхойлжээ.

Улс орны жендэрийн үнэлгээний тайланд (АХБ, ШХА болон ЖҮХ 2010, 50), “Монгол Улс нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн сайн тогтолцоотой” хэмээн дурдсан байдаг. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, шударга тэгш оролцоо, эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн дунд үйлчлэх нийгмийн шударга ёс зэрэг үндсэн асуудлуудыг дээр дурдсан хууль эрх зүйн баримт бичгүүдэд дурдсан байдаг.

2011 оноос өмнө Монгол Улсад жендэрийн асуудлыг зохицуулсан, тусгайлсан хууль байгаагүй учир энэ хуулийг батлан гаргасан явдал бол жендэрийн эрх тэгш байдлыг

*1990 оноос
хийгдсэн нийгмийн
шинэчлэлтэй
холбогдуулан
эмэгтэйчүүдийн
эрхийг хамгаалах
талаар илүүтэй
анхаарах болсон
бөгөөд 1992 оны
Монгол Улсын Үндсэн
хууль хүйсийн
тэнцвэрт байдлыг
хангах тухай заасан
байдаг.*

хөхиүлэн дэмжихэд чиглэсэн маш чухал алхам болж чадсан юм. (ОУСК-Дэлхийн Банк 2013). Ямартай ч энэхүү хуулийн хэрэгжилтийг илүү сайн түвшинд хангаж ажиллах шаардлага байна гэсэн дүгнэлтийг хэд хэдэн тайланд онцлон тэмдэглэсэн байна (ж.нь. Хан , Аслам 2013, ОУВК 2013, МСС 2013).

1.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах Дунд хугацааны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө (2013-2016)

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах Дунд хугацааны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг 2013 оны 1 сарын 26-ны өдөр баталжээ. Энэхүү стратегийн гол зорилгууд нь:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хуулийг хэрэгжүүлэх салбарын болон орон нутгийн чадавхыг бүрдүүлэх, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бүх түвшний бодлого, үйл явцад нэвтрүүлэх, хуулийн хэрэгжилтэд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн олон талт оролцоог хангах, нөөц бололцоо, санхүүжилтийн тогтвортой байдлыг бий болгох, олон улсын хамтын ажиллагааг уялдуулахад оршино. (МУЗГ, Тогтоол #34, 2013 оны 1 сарын 26).

*Улс орны жендэрийн
үнэлгээний тайланд
(АХБ, ШХА болон ЖҮХ
2010, 50), "Монгол
Улс нь жендэрийн
эрх тэгш байдлыг
хангахад чиглэсэн
эрх зүйн сайн
тогтолцоотой" хэмээн
дурдсан байдаг.*

Дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтыг дэвшүүлсэн бөгөөд эдгээр зорилтын хүрээнд хүлээгдэж буй үр дүнг зорилт тус бүрээр тодорхойлж, 2013-2016 оны хооронд хэрэгжүүлэх үүрэг хүлээн ажиллах, тэргүүлэн гүйцэтгэгч талуудыг сонгон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгажээ. Үүнд:

Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үлгэрчилсэн хэлбэр, тэргүүлэн гүйцэтгэгчийг тодорхойлж, хүний нөөцийг сургаж, бэлтгэх замаар үндэсний чадавхыг бүрдүүлнэ.

Зорилт 2. Жендэрийн асуудлаар статистикийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн хөгжүүлж, түүнийг бүх шатны бодлого боловсруулахад ашиглана.

Зорилт 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн холбогдох хууль, эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, хууль хэрэгжих нэгдмэл орчинг бүрдүүлнэ.

Зорилт 4. Бүх нийтийн жендэрийн боловсрол, соёлыг дэмжсэн албан болон насан туршийн боловсролын тогтолцоог бий болгон хөгжүүлж, гэгээрэл сурталчилгааны ажлыг үндэсний хэмжээнд өрнүүлнэ.

Зорилт 5. Жендэрийн шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг бууруулж, түүнээс урьдчилан сэргийлэх орчинг бүрдүүлж, жендэрийн эрх тэгш байдал зөрчигдсөн тухай гомдлыг хянан шийдвэрлэх талаарх хуулийн хэрэгжилтийг хангах механизмыг бий болгоно.

Зорилт 6. Жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох арга зүйг улсын нэгдсэн болон орон нутгийн төсвийг боловсруулах, батлах үйл явцад нэвтрүүлнэ.

1.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 1995 онд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн олон улсын дөрөвдүгээр бага хурлын дараагаар Бээжингийн тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөрийн үзэл санааг үндэсний онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар "Эмэгтэйчүүдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

2000"-ийг төрийн бүс байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр баталсан юм. Энэхүү хөтөлбөр нь 2002 онд "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр" болон шинэчлэгдсэн байна.

Хөтөлбөрт "улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангахад тохиолдож байгаа бэрхшээлийг арилгах, тэдний идэвхтэй хамтын оролцоотойгоор хөгжилд хүрэх, юуны өмнө нийгмийн анхдагч нэгж болох гэр бүлийн хөгжлийг дэмжих, шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангахыг эн тэргүүнд чухалчлахыг зорилт болгоно" гэж тодорхойлсон байдаг. Хөтөлбөрт бүх шатны шийдвэр гаргах үйл явцад жендэрийн эрх тэгш байдлыг хангах явдлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн нэг байна гэж тодорхойлжээ (ЖҮХ 2002).

Хөтөлбөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь дараах салбаруудад хэрэгжүүлэх нийт 15 зорилтыг хангахад чиглэгдсэн юм. Эдгээрийг багцлан үзүүлбэл:

- Гэр бүлийн хөгжил дэх жендэрийн тэгш байдал
- Эдийн засгийн харилцаан дахь жендэрийн тэгш байдал
- Хөдөөгийн хөгжил дэх жендэрийн тэгш байдал
- Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдал
- Жендэрийн асуудлаарх үндэсний тогтолцоо ба иргэний нийгмийн оролцоо

"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг баталсны дараагаар Засгийн газрын зүгээс үндэсний хэмжээнд жендэрийн тэгш эрх, эмэгтэйчүүдийн оролцооны талаар мэдээлэл түгээж эхэлсэн юм. Ямартай ч Улс орны жендэрийн үнэлгээний тайланд "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв маш хязгаарлагдмал, тиймээс хөтөлбөрийн үр нөлөө багасч, зөвхөн цаасан дээр бичигдэн үлджээ." хэмээн дүгнэсэн байна (АХБ, ЖҮХ 2010).

1.6. Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн үндэсний механизм

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулиар Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулахад жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах үүрэг, хариуцлагыг ногдуулсан байдаг бол Хүний Эрхийн Үндэсний Комисст Үндсэн хууль болон бусад хуульд орсон жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн зүйл, заалтын хэрэгжилтэд хяналт тавих эрхийг олгосон байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль нь Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхий сайд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах шаардлага тавьсан байна. Мөн түүнчлэн Жендэрийн Үндэсний Хороо, төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгсөн байна. Иргэний нийгэм болон ТББ-уудын үүрэг оролцоог мөн энэ хуульд дараах байдлаар онцолсон байдаг: "Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого, бусад шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавихад оролцох, иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах; төрийн байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой мэдээлэл, санхүү, арга зүйн болон бусад дэмжлэг авах, жендэрийн эрх тэгш байдлын талаар саналаа илэрхийлэх."

"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв маш хязгаарлагдмал, тиймээс хөтөлбөрийн үр нөлөө багасч, зөвхөн цаасан дээр бичигдэн үлджээ."

"Эмэгтэй, эрэгтэй хүмүүс эрх чөлөөтэй, нэр төртэй амьдрах тэгш боломжийг эдэлж чадсан тэр л цагт тогтвортой хөгжил, хүний эрх, энх тайван оршин тогтнох боломжтой."

Хэдийгээр салбарын яамд болон дүүргийн түвшинд жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн томилж хүний нөөцийн асуудлаа шийдвэрлэж байгаа ч, Жендэрийн Үндэсний Хорооны харъяа 25 салбар зөвлөлийн үйл ажиллагаа төдийлэн идэвхтэй бус, салбарын хөгжлийг тодорхойлж буй бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн тэгш байдлын зарчмуудыг тусгах, үйл хэрэг болгох тал дээр сул ажиллаж байгаа нь тухайн яамд, тамгын газруудад жендэрийн эрх тэгш байдлыг хангахын ач холбогдлыг удирдлагын түвшинд сайтар ойлгоогүй, мэдлэг, мэдээлэл дутуу байгаатай холбоотой юм. Цаашлаад дээрх газруудад жендэрийн мэргэжилтнээр томилогдон ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн дийлэнх нь мэргэжлийн бус, өөрийн үндсэн үүрэг, хариуцлагын хажуугаар давхар үүрэг хүлээн ажиллаж байгаа нь, салбарын яамд, дүүрэг, орон нутагт жендэрийн чиглэлээр ажиллаж буй мэргэжилтэн, ажилтнуудын чадавх сул хэвээр байгааг харуулж байна.

Азийн Хөгжлийн Банк, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Жендэрийн Үндэсний Хорооноос 2010 онд боловсруулан гаргасан тайланд "ЖҮХ-ний ажлын алба хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаа үндэсний хэмжээнд гүйцэтгэхэд бүтэц, зохион байгуулалтын хувьд техникийн болон мэргэжлийн чадавх дутагдаж байна. Орон нутагт жендэрийн мэргэжилтнээр ажиллаж буй албан тушаалтнуудын дийлэнх нь нийгмийн ажилтан гэх мэт доод түвшний, эрх мэдэл багатай албан тушаалтан байдаг бөгөөд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд эдгээр мэргэжилтнүүдийг сургах, мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах сургалт харьцангуй бага зохион байгуулагдсан юм" гэжээ.

2. Нийгмийн бодит нөхцөл байдал.

"Эмэгтэй, эрэгтэй хүмүүс эрх чөлөөтэй, нэр төртэй амьдрах тэгш боломжийг эдэлж чадсан тэр л цагт тогтвортой хөгжил, хүний эрх, энх тайван оршин тогтнох боломжтой. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс бүх түвшинд чанартай боловсрол эзэмших, боломж бололцоог эдлэх, ажил хөдөлмөр эрхлэх, өөрийн мэдлэг, чадвар, эрх мэдлийг тэгш хуваалцах боломжтой тэр л үед тэгш байдал оршдог. Жендэрийн тэгш байдлын асуудлыг бодит шаардлага, ёс зүйн зайлшгүй нөхцөл гэж харах ёстой" (Редакторын ишлэл).

Ирина Бокова, ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал

2.1. Жендэрийн зөрүүтэй байдлын индекс - Монгол Улс
Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын тайланд, Монгол Улс эдийн засгийн оролцоо, боломжийн индекс /хөдөлмөрийн харилцааны зөрүүтэй байдал үүнд хамаарна/ цалин хөлсийн зөрүүтэй байдал зэрэг үзүүлэлтээрээ 0.834 гэсэн индекстэй гарсан байна. Энэ нь дэлхийн 136 орноос 2 дугаарт буюу Норвегийн дараа, Бурунди улсын өмнө бичигдсэн.

Эмэгтэйчүүдийн Дэлхий нийтийн 4 дэх бага хурлаас гаргасан тунхагт "Эмэгтэйчүүдийн эрх мэдэл, нийгмийн бүхий л салбарын харилцаанд эрх тэгш оролцох боломж, тэр дундаа шийдвэр гаргах үйл явц дахь оролцоо, эрх мэдэлд хүрэх боломж зэрэг нь нийгмийн тэгш байдал, хөгжил, энх тайванд хүрэх үндсэн тулгуур байх болно" хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.

Монгол Улс 2013 онд Хүний Хөгжлийн Индексээр 108-р байранд жагссан (дэлхийн 207 орноос) нь хүний хөгжлийн дундад түвшний үзүүлэлттэй орон гэж дүгнэхэд хүргэсэн байна (ХХИ 0.675) (НҮБХХ 2013). 2012 онд Монгол Улсын Жендэрийн тэгш бус байдлын индекс 5615 байсан бол, Жендэрийн зөрүүтэй байдлын индексийн дэд индекс болох Улс төрийн эрх мэдэл /үүнийг улс төрийн шийдвэр гаргах түвшний хамгийн дээд албан тушаалд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэйн хүмүүсийн тооны харьцаа гэсэн үзүүлэлтээр тооцдог/ гэсэн үзүүлэлтээр Монгол Улс 0.211 гэсэн индексээр дэлхийн 136 орноос 108-р байранд жагссан байдаг.

2.2. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл.

Д/д 1990 оны МХЗ-уудын хэрэгжилтийг үнэлэх аргачлал

он:	1990	2000	2004	2008	2012	2016
Парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь	24.9	11.8	6.6	3.9	14.47	17.1
Парламентад нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн хувь	7.7	10.9	13.7	18.5	32.0	

Сүүлийн хоёр сонгуулийн статистикийг харвал 2008 онд 356 нэр дэвшигчийн 66 нь эмэгтэй байж 3 нь, 2012 онд 544 нэр дэвшигчийн 174 нь эмэгтэй байж үүнээс 11 нь сонгогдож байсан. Харин саяхан болж өнгөрсөн УИХ-ын сонгуульд 498 хүн нэр дэвшиж өрсөлдсөнөөс 129 нь эмэгтэй нэр дэвшигч байлаа. Сонгуулийн болон бусад хуулинд жендэрийн квот тогтоож өгсөн нь ("Сонгуулийн хуулийн 126.2. Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.") үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг мэдэгдэхүйц түвшинд нэмэгдүүлж, богино хугацаанд хэрхэн хурдтай ажиллаж, үр дүнд хүрч болохыг харуулсан үйл явдал болсон юм. Олон улсын байгууллагын өөр эх сурвалжийн үзсэнээр дээрх хурдан хугацаанд үр дүн авчрах бодлогоос гадна өндөр дээд түвшинд төрийн алба хашиж байгаа эрэгтэй удирдлагууд авилга, хээл хахуулын хэрэгт холбогдох нь ихсэж, иргэдийн итгэл найдварыг алдах болсон нь найдвартай, зарчимч, эмэгтэй удирдагч, улс төрчдөд итгэх нөхцөлийг бүрдүүлж, сонгуулиар дээр дурдсан эерэг үр дүнг авчирсан байна.

Эмэгтэй нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгаа явуулахад шаардагдах хөрөнгө босгоход ихээхэн хүндрэлтэй байдаг. Одоо хэрэгжиж буй хуулиудад сонгуулийн кампанит ажлын санхүүжилт босгох арга замын тухай тодорхой заалт байхгүй, харин зардлыг хэрхэн зарцуулах тухайд заалтууд бий. Зардлыг хязгаарлах заалт сул байгаа нь хөрөнгөтэй нэр дэвшигч, улс төрийн намуудад илүү боломж олгож байна. Хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих мөн хүлээлгэх хариуцлага сул байгаагаас намууд, нэр дэвшигчид сонгогдсоныхоо дараа бизнесийн ашиг сонирхолд автах эрсдэлтэй байна. Манай улсад одоог хүртэл эрэгтэйчүүд давамгайлсан парламентын гишүүдийн дунд бизнес эрхэлдэг гишүүд олон байдаг. Тиймээс улс төрд бизнесийн ашиг сонирхлын нөлөө их, томоохон компаниуд сонгуулийг санхүүжүүлж байгаа нь улс төрд орж буй эмэгтэйчүүд

Сонгуулийн болон бусад хуулинд жендэрийн квот тогтоож өгсөн нь ("Сонгуулийн хуулийн 126.2. Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.") үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг мэдэгдэхүйц түвшинд нэмэгдүүлж, богино хугацаанд хэрхэн хурдтай ажиллаж, үр дүнд хүрч болохыг харуулсан үйл явдал болсон юм.

Эмэгтэй нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгаа явуулахад шаардагдах хөрөнгө босгоход ихээхэн хүндрэлтэй байдаг.

Улс төрд бизнесийн ашиг сонирхлын нөлөө их, томоохон компаниуд сонгуулийг санхүүжүүлж байгаа нь улс төрд орж буй эмэгтэйчүүд болон бага орлоготой эрэгтэй нэр дэвшигч сонгогдоход саад бэрхшээл болсоор байна.

болон бага орлоготой эрэгтэй нэр дэвшигч сонгогдоход саад бэрхшээл болсоор байна. Энэ нь улс төрийн гараа тэгш бус байгааг мөн нэгэнт парламентад эрэгтэйчүүд давамгайл байгаа тул дахин сонгогдох боломж мөн эрэгтэйчүүдэд илүү байгааг харуулж байна. Түүнчлэн нам дотроо нэр дэвших эрх авах “нэр дэвшигчийн татвар” гэсэн өндөр босго тавьдаг. Статистик мэдээнээс харвал томоохон компанийн захирал, менежерүүдийн 74 хувийг эрэгтэйчүүд эзэлж байнгаа нь эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд ялгаварлал, бэрхшээл учруулж байна.

2.3.Бие даасан судалгаанууд.

IRIM Судалгааны байгууллагын хийсэн судалгаагаар орон нутгийн сонгуульд өрсөлдөж ялагдсан эмэгтэй нэр дэвшигчдийн ялагдсан шалтгаанд 1 дүгээрт нэр дэвшиж өрсөлдсөн намын нэр хүнд, 2 дугаарт сонгуулийн сурталчилгааны компанит ажлын зохион байгуулалт орсон байдаг. Харин эрэгтэй нэр дэвшигчдийн хувьд энэ байдал арай өөрөөр буюу хувь хүний өөрийн хүчин зүйлс ихээхэн нөлөөтэй байдаг нь ажиглагддаг. Мөн дараах албан тушаалд эмэгтэй, эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин хэд байвал зохистой вэ?

Албан тушаал	Эрэгтэй	Эмэгтэй
Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	60	40
Сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	50	50

“Стратеги Академи” ТББ-аас УИХ-ын сонгуулийн өмнө 2015, 2016 онуудад хийсэн “Хүсэмжит улс төрч” болон монголын улс төрчдийн рейтингийн судалгаануудаас харахад ч гэсэн иргэд сонгогчид “Та УИХ-ын сонгуульд ямар хүн нэр дэвшүүлбэл илүүтэй дэмжих вэ?” хэмээн асуухад 51.4 хувь нь эрэгтэй нэр дэвшигчийг, 35.2 хувь нь эмэгтэй нэр дэвшигч байх нь зүйтэй хэмээн хариулсан байдаг. Энэ нь эрэгтэй улс төрчдөд арай илүү боломж бололцоог олгох суурь нь болж өгч байна. /энэ дүн нь мөн л эмэгтэйчүүд улс төрийн мэдлэг, мэдээллээс эмэгтэйчүүд арай л хол хөндий байдгийг харуулж байна./

Улс төрийн мэдлэг, мэдээллийн байдал	Эр 58.7
	Эм 23.6

Нийгмийн Ардчилал Монголын Эмэгтэйчүүдийн Холбооноос явуулсан “Монголын эмэгтэйчүүдийн амьдралын чанарын судалгаагаар нийт эмэгтэйчүүдийн 58,6 хувь нь сонгуульд санал өгөхөөс өөрөөр орон нутгийн улс төрийн асуудалд ямар нэгэн хэмжээгээр оролцдог” гэжээ. Энэ дүн бол насанд хүрсэн эмэгтэйчүүдийн хувьд чамлахаар үзүүлэлт биш гэж хэлж болно. Мөн 63.6 хувь нь улс төрд эрчүүдийн адил оролцох шаардлагатай, улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо тааруухан хэмээн 84.3 хувь нь үзэж байна. Гэвч харамсалтай нь судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 70.8

хувь нь ямарваа нэгэн улс төрийн сонгуульд нэр дэвшин өрсөлдөх талаар огт бодож байгаагүй байна. Гэтэл дээд боловсролын байгууллагууд дахь элсэлт 69:46 хувь буюу эмэгтэйчүүдийн дээд боловсрол эзэмших байдал харьцангуй давуу байна. Мөн дээрх судалгаанаас гарсан үр дүнгээр монголын эмэгтэйчүүд гэр орныхоо бүхий л ачааг нуруун дээрээ үүрч явдаг нь харагдсан билээ. Үүнд: Өрх гэрийн санхүүг босгох, үр хүүхдийн боловсролд анхаарах, гэр орныхоо бүхий л ажлыг бие даан хийх зэргээр өөртөө сурч боловсрох буюу мэргэжлээ дээшлүүлэх, улс төр, нийгмийн амьдралд оролцох зэрэг цаг зав гаргах бололцоогүй байдаг байна. Үүний гол шалтгааныг тэд нэрлэхдээ эр нөхөрт нь боловсрол, мэргэжил байдаггүй, тэдэнд ажил олддоггүй, олдсон ажлын байрных нь нөхцөл хүнд, цалинг нь өгдөггүй зэргээс шалтгаалан эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн чадвар эрүүл мэнд муудах, архинд орох цаашилбал амь насаа алдах тохиолдол ч их гардаг байна.

Дээр дурдсанаар эрчүүдийн амьдралын хэв маягтай холбоотой өвчлөлт, нас баралтын хувь өндөр байгаа нь урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг түлхүү олгох шаардлага байгааг илтгэн харуулж байна. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал сул байгаагийн үндсэн шалтгаануудын нэг бол тэдний халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэхийн ач тусын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа явдал юм. Энэ нь эрэгтэйчүүдийн зан үйл, дадал хандлагыг яаралтай өөрчлөх шаардлага байгааг харуулж байна. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал ийнхүү анхаарал татсан асуудал болсон тул Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13.1-р зүйл "Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээ бий болгоход чиглэсэн арга хэмжээ авна" хэмээн зааснаас гадна, ЭМЯ-ны зүгээс 2014-2018 оны хооронд хэрэгжүүлэх Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн стратегийг боловсруулж, 2014 онд соёрхон баталсан байна.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл жендэрийн асуудлыг тэр дундаа шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд нийгмийн бүхий л салбар хүрээг хамарсан үндэсний хэмжээний бодлогуудыг илүү нягт нямбай боловсруулан, амьдралд бодитоор хэрэгжүүлэх нөхцлөөр хангаж ажиллах шаардлага бидэнд байна. Тухайлбал: Өнөөг хүртэл Монгол Улс хөгжлийнхөө тэргүүлэх чиглэлийг тодорхойлж чадсангүй. Үүнээс хамаарч байх ёстой боловсрол мэргэжлийн тогтолцоо ямарч хяналтгүй, эмх замбараагүй явж ирсний балгаар ажлын байрны шаардлага хангадаггүй, мэргэжил нь тохирдоггүй, зөвхөн дээд боловсролын диплом өвөртлөсөн ажилгүйчүүдийн арми бий болоод байна. Эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд бүгд ажлын байраар найдвартай хангагдан, санхүүгийн найдвартай эх үүсвэртэй болсон үед л эмэгтэйчүүдийн нуруун дээрх хүнд ачаа багасч эрчүүд нь өрх гэрээ бүрэн бүтэн аваад явах, эмэгтэйчүүд нийгэм улс төрийн амьдралд шийдвэртэй оролцох нөхцөл бий болох ёстой юм.

Эмэгтэйчүүд аливаа асуудалд илүү прагматик, хичээнгүй, аливаа дүрэм журам болон нийгэмд хэвшиж тогтсон ойлголтыг ягштал дагаж баримталдаг тул шийдвэр гаргах түвшинд төдийгүй аливаа байгууллага хамт олны дотор албан харилцаа найдвартай үйлчилж байдаг. Дан эрчүүдээс

*Эмэгтэйчүүд болон
эрэгтэйчүүд бүгд
ажлын байраар
найдвартай
хангагдан,
санхүүгийн
найдвартай эх
үүсвэртэй болсон үед
л эмэгтэйчүүдийн
нуруун дээрх хүнд
ачаа багасч эрчүүд
нь өрх гэрээ бүрэн
бүтэн аваад явах,
эмэгтэйчүүд нийгэм
улс төрийн амьдралд
шийдвэртэй оролцох
нөхцөл бий болох
ёстой юм.*

бүрдсэн хамт олон дотор албан харилцааны үүрэг роль бага байдаг билээ.

ДҮГНЭЛТ

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах. Жендэрийн Үндэсний Хорооны харъяа салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, салбарын хөгжлийг тодорхойлж буй бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн тэгш байдлын зарчмуудыг тусгах, төрийн байгууллагуудын удирдлагын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах мэдлэг, мэдээллээр хангах, төрийн албаны жендэрийн асуудал хариуцсан ажилтныг орон тооны болгох талаар анхаарах,

2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн үзэж, дараагийн шатны төлөвлөгөөг боловсруулах,

3. Эмэгтэйчүүдийн улс төрийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх. Үүний тулд улс төрийн намууд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд манлайлагч байж эмэгтэй гишүүд дэмжигчдийг сургах, дадлагажуулах, улс төрийн мэдлэгийг олгох системийг бий болгох. Эмэгтэй нэр дэвшигчдийн сонгуулийн компанит ажилд туслах тусгайлсан хөтөлбөрөөр ажиллах дотоод журмыг боловсруулан мөрдлөг болгон ажиллах,

4. Эмэгтэйчүүдийг амьдралын өдөр тутмын хүндрэлтэй асуудлуудаас хөндийрүүлэх гол зам бол эрэгтэйчүүдийн ажил хөдөлмөр эрхлэлт болон эрүүл мэндийн асуудал байдаг тул Монгол Улсын хөгжлийн хөтөлбөрийг хүртэл эргэн харах, хөгжлийн чиглэлээ нарийвчлан тодорхойлж, боловсролын тогтолцоонд хүүхдийг бага балчраасаа мэргэжлийн чиг баримжаатай болгож сургах тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Та бүхэнд баярлалаа.

Агваанлуvsангийн Ундраа,

МУ-ын УИХ-ын гишүүн

Эмэгтэйчүүдийн
улс төрийн
идэвх, оролцоог
нэмэгдүүлэхийн
тулд улс төрийн
намууд Жендэрийн
эрх тэгш байдлыг
хангах тухай хуулийг
хэрэгжүүлэхэд
манлайлагч байж,
эмэгтэй гишүүд
дэмжигчдийг сургах,
дадлагажуулах, улс
төрийн мэдлэгийг
олгох системийг бий
болгох шаардлагатай.

“УЛС ТӨР ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮД: СААД БЭРХШЭЭЛ БОЛОН БОЛОМЖУУД” ПАНЕЛ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ОНЦЛОХ ЭШЛЭЛҮҮД

“Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоогоор дамжуулан ардчиллыг бэхжүүлэх нь” сэдэвт Монгол-Германы XIV Чуулганы нэг онцлог нь тус чуулганы хөтөлбөрийн уламжлалт хэв маягт өөрчлөлт оруулж, чуулганы сэдвийн хүрээнд тодорхой мэдлэг, туршлага бүхий төлөөллүүдийг оролцуулсан панел хэлэлцүүлгийг зохион байгуулсан явдал байв. Бид энэ удаагийн панел хэлэлцүүлэгтээ Монгол Улсын 21 дэх Ерөнхий сайд бөгөөд УИХ-ын гишүүн асан Ринчиннямын Амаржаргал, Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ-ын Захирал Батхуягийн Золзаяа, ХБНГУ-ын Тюринген муж улсын Ерөнхий сайд асан бөгөөд тус муж улсын Ландтагийн гишүүн Кристине Лийберкнэхт болон МУ-ын УИХ-ын гишүүн Загдхүүгийн Нарантуяа нарыг урьж оролцуулсан юм. Панел хэлэлцүүлгийн үеэр панелистуудын хэлсэн онцлох эшлэлүүдийг та бүхэнд хүргэж байна.

Монгол Улсын 21 дэх Ерөнхий сайд бөгөөд УИХ-ын гишүүн асан Ринчиннямын Амаржаргал:

Парламент бол аливаа улсын бүхий л төлөөллөөс бүрдэх учиртай институт. Өнөөгийн засаглалын тогтолцооны хүрээнд сонгуулийн пропорциональ систем нь үүнийг биелүүлэх боломжийг олгоно. Иймд бид сонгуулийн мажоритар системд эргэн шилжсэн нь шийдвэр гаргах түвшинд олон талт төлөөллийг хангах үйл явцаас ухарснаас ялгаагүй хэрэг болсон.

Эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоо жам ёсоороо нэмэгдэж, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн шийдвэр гаргах түвшин дэх төлөөллийн харьцаа цаг хугацааны явцад тэнцвэржиж байна. Үүнийг хэн ч, юу ч зогсоож чадахгүй. Харин зүй ёсоороо явж буй энэ үйл явцыг гадны нөлөөллөөр гажуудуулахгүй байх нь чухал юм.



Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ-ын Захирал Батхуягийн Золзаяа:



Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэй улс төрчид олон нийтийн зүгээс давхар шаардлага, шүүлттэй тулгарах нь олонтаа. Жишээ нь эмэгтэй хүн учраас зөвхөн нийгмийн халамж, хамгааллын асуудлуудад илүү төвлөрч ажиллах ёстой мэтээр тэднийг харах нь элбэг. Цаашлаад тэдний бодлого боловсруулагч, сонгогдсон төлөөлөгч гэдгээр нь

харах бус харин гадаад төрх, гэр бүлийн амьдрал зэрэг хувь хүний холбогдолтой асуудлуудыг нь олон нийтийн дунд асуудал болгон тавьж, хурцаар шүүмжлэх нь манай нийгмийн тогтсон дүр зураг.

Жендэрийн тэгш эрх бол зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш. Энэ бол ардчиллын оршин тогтнолын нэг гол илэрхийлэл, хэмжүүр юм. Ардчилсан засаглалын гол үнэт зүйл нь оролцоо, өөрөөр хэлбэл тухайн нийгмийн иргэд шийдвэр гаргахад оролцож чадаж байгаа эсэх асуудал. Гэтэл өнөөгийн Монголд шийдвэр гаргах түвшин дэх оролцогчдыг хүнээр төлөөлүүлэн төсөөлбөл нийгмийн дунджаас дээш давхаргын, хөрөнгө чинээ, холбоо сүлбээтэй 50 орчим насны эрэгтэй дүрслэгдэж байна. Тэгэхээр нийгмийн нэг л, тэр дундаа маш цөөнх болох энэ бүлэг нийгмийн бусад бүлэгт ээлтэй, мэдрэмжтэй шийдвэр гаргаж чадахгүй байна.

ХБНГУ-ын Тюринген муж улсын Ерөнхий сайд асан бөгөөд муж улсын Ландтагийн гишүүн Кристине Лийберкнехт:



Бид эмэгтэйчүүдийн эрхийг болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлын хөгжлийн шатанд явж байна. Германд улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр маш их ахиц дэвшил гарсан. Харин эдийн засгийн салбарт сайжрах шаардлага байна. Учир нь тус салбарын удирдах албан тушаалтнуудын ердөө 11 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Энэ нь Монголын байдалтай харьцуулахад эрс өөр дүр зураг юм. Учир нь Монгол Улсын эдийн засгийн салбарт хамаагүй олон эмэгтэй удирдах албан тушаал хашдаг.

Дэлхийн II дайны дараа буюу Германд национал-социализмыг устгасны дараагаар бид ардчиллыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн. Үүний салшгүй нэг хэсэг нь иргэдэд улс төрийн боловсролыг идэвхтэй олгох явдал юм. Зөвхөн идэвхтэй бөгөөд чанартай улс төрийн боловсролоор дамжуулан бид ард түмний улс төрийн зохистой оролцоог дэмжиж чадна.

МУ-ын УИХ-ын гишүүн Загдхүүгийн Нарантуяа:

Монгол эмэгтэй хүний хувьд маш олон давааг давсны хүчинд улс төрийн шийдвэр гаргах түвшинд гарч ирэх боломж бүрддэг. Нэгдүгээрт, өөрийгөө, тэр дундаа сэтгэл зүйгээ маш сайн бэлтгэх шаардлага тулгардаг. Хоёрдугаарт, Монголын өнөөгийн нөхцөл байдалд улс төрийн нам дотроо хүлээн зөвшөөрөгдөөд сонгуульд өрсөлдөх эрхээ гардаж авна гэдэг хамгийн том даваа юм.



Бага насны хүүхдээ гэртээ асардаг эсвэл хөдөлмөр эрхлэх хүсэлтэй ахиаг насны эмэгтэйчүүдийн ажилгүйдэл нь монгол эмэгтэйчүүдийн хувьд тулгамдаж буй нэн тэргүүний асуудал юм. Иймд хүүхэд асрах үйлчилгээ үзүүлэх эсвэл гэртээ үйлдвэрлэл эрхлэх эдийн засгийн болон эрх зүйн орчныг нь тэдгээр хөдөлмөрлөх чин хүсэл эрмэлзэлтэй, чадвартай эмэгтэйчүүдэд бүрдүүлэн өгч дэмжих шаардлагатай байна. Хөдөлмөрлөх тэгш боломжоос манлайлах тэгш боломж үүснэ.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД БА ТЭДГЭЭРИЙН ХҮРЭЭН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Өнгөрсөн жил дэлхий нийт “2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр” болон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг (ТХЗ) баталсан. ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Учир нь ТХЗ-н олон зорилт эмэгтэйчүүдийн тэгш эрх болон тэгш байдлыг хангахыг буюу эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийг зорилгоо болгодог бөгөөд ингэх нь бусад зорилтуудыг биелүүлэх арга зам гэж үзэж байна.

ТХЗ нь хөгжлийг дэмжих өөр, илүү цогц аргачлал олох зорилготой. ТХЗ-ууд нь Мянганы хөгжлийн зорилтуудын (МХЗ) биелэлтийг ахиулж, бодит өөрчлөлтийг бий болгохын тулд тэгш бус байдлыг арилгах, нийгмийн эдийн засгийн бус цочролыг даван туулах чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн бүтцийн хэврэг байдлыг багасгах болон засаглалын алдаатай байдлыг засах зэрэг хөгжлийн үндсэн бэрхшээлүүдтэй тулж ажиллах шаардлагатай. Эдгээр нь харилцан уялдаатай асуудлууд бөгөөд би заримаас нь нарийвчлан дэлгэрүүлж танилцуулъя.

Тэгш бус байдал

2014 оны нэгдүгээр сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс (НҮБХХ) хөгжиж буй орнууд дахь тэгш бус байдлын тухай нэг чухал тайланг нийтэлсэн. Уг тайланг “Хуваагдмал хүн төрөлхтөн” (Humanity Divided) гэж нэрлэсэн бөгөөд хувь хүний амьдрал дахь тэгш бус байдал бүх нийгмийн ирээдүйд хэрхэн сөрөг нөлөө үзүүлж байгаад тус тайлангийн хүрээнд дүн шинжилгээ хийжээ.

Тэгш бус байдал газар авсан бол ядуурлыг бууруулах асуудал хэцүү болдог. Дэлхийн банкнаас “Тэгш бус байдал газар авсан нэг ч улс дунджаас илүү орлогын түвшинд хүрч чадаагүй” гэж тэмдэглэсэн байна. Тооноос харахад, эдийн засгийн эрх мэдэл хэдхэн хүний гарт төвлөрсөн газар улс төрийн эрх мэдэл мөн хэсэг бүлэг элитүүдийн гарт байдаг байна. Энэ нь тэгш байдлыг сайжруулах оролдлогод бүтцийн саад учруулдаг. Жишээ нь урвуу татвар тогтоох, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулахгүй байх зэрэг нь тэртэй тэргүй энэ үйлчилгээг бараг авч чаддаггүй нийгмийн эмзэг бүлэгт бүр илүү сөргөөр нөлөөлнө. Тэгш бус байдал нь улс төрийн эрх мэдэл тэгш бус хуваарилагдахад хүргэдэг. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагууд тэгш бус хуваарилалт хийж, ингэснээрээ эдийн засгийн системийг бүхэлд нь доройтуулдаг. Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл тэгш бус байдал нь зөвхөн эд хөрөнгөтэй бус мөн эрх мэдэлтэй холбоотой бөгөөд ийм утгаараа ардчилалд нөлөөлдөг байна. Тэгш бус байдал нь дундаж наслалт богиносох, сэтгэцийн эрүүл мэнд муудах, аж амьдрал доройтох болон гэмт хэрэг өсөх зэрэг нийгмийн олон сөрөг үр дагаврыг бий болгодог. Эдгээр нь санхүүгийн нэмэлт ачааллыг бий болгодог. Хэдхэн хоногийн өмнө (9 дүгээр сарын 26-нд) нийтлэгдсэн НҮБХХ-ийн Африкийн Хүний хөгжлийн 2016 оны тайланд Африк тив дэх Сахарын цөлөөс өмнөх хэсэгт хүйсийн



Тогтвортой хөгжлийн зорилтуудыг (ТХЗ) хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Учир нь ТХЗ-н олон зорилт эмэгтэйчүүдийн тэгш эрх болон тэгш байдлыг хангахыг буюу эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийг зорилгоо болгодог бөгөөд ингэх нь бусад зорилтуудыг биелүүлэх арга зам гэж үзэж байна.

Тэгш бус байдлын эсрэг тэмцлийн гол элемент нь хүйсийн тэгш байдлыг хангах юм. Зөвхөн Нэгдсэн Үндэстний Байгууллага тэгш эрхийг хүний эрх гэж харж байгаа юм биш, харин нийгэмд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрх бэхжиж суурьшсан цагт л аливаа нийгэм өөрийн боломжоо бүрэн ашиглаж чадах нь тодорхой билээ.

ялгаатай байдал жил бүр дунджаар 95 тэрбум америк доллар буюу тус бүс нутгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувьтай тэнцэх зардлыг үүсгэж байна гэжээ. 2014 онд энэ хэмжээ бүр 105 тэрбум америк доллар байжээ. Энэ нь тус тивийн хүртээмжтэй хүний хөгжил болон эдийн засгийн хөгжлийн өсөлтийг урагшлуулахад бэрхшээл бий болгож байна. Уг зардлыг тооцоолохдоо эмнэлгийн эмчилгээний зардал, эрүүл мэндийн өвчлөлтийн байдал болон дундаж наслалтын бууралтаас үүсэх алдагдал мөн хорих газрын зардал зэргийг нэгтгэж боддог. Гэвч тэгш бус байдлын нийгэмд үзүүлж буй олон сөрөг нөлөө, тухайлбал нийгмийн эв нэгдэл, итгэлцэл болон нийгмийн дасан зохицох байдал зэргийн алдагдлыг тооцоолон гаргах боломжгүй юм.

Тэгш бус байдлын эсрэг тэмцлийн гол элемент нь хүйсийн тэгш байдлыг хангах юм. Зөвхөн Нэгдсэн Үндэстний Байгууллага тэгш эрхийг хүний эрх гэж харж байгаа юм биш, харин нийгэмд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрх бэхжиж суурьшсан цагт л аливаа нийгэм өөрийн боломжоо бүрэн ашиглаж чадах нь тодорхой билээ. Охид, эмэгтэйчүүдэд хөрөнгө оруулах нь үе дамжсан, нийт нийгмийг хамарсан эерэг өөрчлөлтийг бий болгодог нь судалгаагаар батлагдсан – охид, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхэд хөрөнгө оруулах нь нийгмийн орлогыг, дундаж наслалтыг мөн боловсролын стандартыг дээшлүүлдэг.

Эмзэг байдал

Ядуурлыг багасгах болон хүмүүсийн ядууралд өртөмтгий байдлыг бууруулах нь ТХЗ-уудын нэг гол зорилт юм. Олон тохиолдолд нийгмийн ядуу бүлэг бүтцийн хувьд эмзэг байдаг. Нийгмийн болон хуулийн байгууллагууд, засаглалын бүтцүүд, улс төрийн орон зай, уламжлал ба нийгэм-соёлын хэвшмэл байдал, хэм хэмжээнүүд хүн бүрт тэгш үйлчлэхгүй байгаа үед бүтцийн эмзэг байдал бий болдог.

Өнөөдөр дэлхий дахинаа амьдралын нөхцөл байдал, хувийн аюулгүй байдал, хүрээлэн буй байгал орчинтой эсвэл олон улсын улс төртэй холбоотой түгшүүртэй, тодорхойгүй байдал ноёрхож байна. Эрүүл мэнд, хүнс тэжээл гэх зэрэг хүний хөгжлийн гол нээлтүүд байгалын гамшиг, санхүүгийн хямрал эсвэл зэвсэгт мөргөлдөөний үед сүйтгэгдэж эсвэл бүрмөсөн устгагдаж болох юм. Судалгаанаас үзэхэд ялангуяа хөгжиж буй орнууд дахь эмэгтэйчүүд үүрэг оролцоо, нөөц баялаг болон эрх мэдлийн тэнцвэргүй хуваарилалтаас болоод ямар нэгэн аюул, байгалын хүнд бэрх гамшиг болон цаг уурын өөрчлөлтөнд харьцангуй өртөмтгий байдаг нь тогтоогджээ.

Энэ өртөмтгий байдал нь далайн хар шуурга, үер зэрэг цаг уурын хэт аюултай үзэгдлийн үеэр эмэгтэйчүүд илүү үрэгддэгээр мөн аюул гамшгийн дараах сэргээн босголтын үед амьд үлдсэн эмэгтэйчүүд амьдралаа эргэн хэвэнд нь оруулахдаа ихэнхдээ хүндрэл бэрхшээлтэй учирдгаар илэрнэ.

Хэдийгээр эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах олон хууль, дүрэм батлагдаж байгаа боловч бэлгийн болон хүйсийн онцлогтой хүчирхийлэл тив болгонд, улс болгонд өргөн тархсан хэвээр ба энэ нь дайн дажин болон мөргөлдөөний үеэр цар хүрээгээ улам хүчтэй тэлдэг. Дэлхий даяарх эмэгтэйчүүдийн гуравны нэг нь амьдралынхаа явцад

бэлгийн болон бусад хүчирхийллийн золиос болж үзсэн байдаг. Энэ бол цочирдмоор их тоо!

2000 оноос НҮБХХ нь өөрийн түншүүд болон дэлхийн бусад орнуудын хамтаар хүйсийн тэгш байдлыг хангах явдлыг ажлынхаа гол төв болгон тодорхойлсон. Бид олон оронд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх явдлыг системтэйгээр дэмжиж, үүний тулд хууль, эрх зүйн шинэчлэлийг дэмжих мөн эмэгтэйчүүдийг улс төрийн албан тушаалд дэвшүүлэхийг олон нийтээр дэмжүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн сурталчилгааг дэмжих зэрэг ажлыг гүйцэтгэж байна. НҮБХХ эрэгтэйчүүдээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдүүлэхгүй байхын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч байна. Энэ нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг дуусгавар болгох UniTE компанит ажлын гол хэсэг юм. Бид мөн улс төрийн намуудтай хүйсийн эрх тэгш байдал сэдвийн хүрээнд хамтран ажиллаж байгаа бөгөөд эмэгтэйчүүдэд олон нийтийн болон улс төрийн шийдвэр гаргах түвшинд ажиллах чадварыг бий болгоход нь дэмжлэг үзүүлж байна. Бид сүүлийн 2 жилд орон нутгийн сонгуульд сонгогдсон 2000 гаруй монгол эмэгтэйг манлайллын сургалтанд хамруулсан. Ази номхон далайн бүсэд бид өөрсдийн хот тосгондоо зөрчил мөргөлдөөнийг зохицуулахад идэвхтэй оролцож байгаа 2000 гаруй эмэгтэйд иргэдийн төлөөлөгчдийн сүлжээ байгуулахад нь тусалсан. Мөн N-Peace хэмээх зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх зорилготой олон улсын сүлжээтэй хамтран ажиллаж, эмэгтэйчүүдийн энх тайвны төлөө гүйцэтгэсэн ажлыг үнэлж олон нийтэд таниулах зорилгоор жил бүр шагнал гардуулах үйл ажиллагаа зохион байгуулж байна.

Эдгээр болон бусад хүчин чармайлтууд алхам алхмаар үр дүнгээ өгч эхэлж байна. Өнөөдөр урьд хожид байгаагүй олон охид сургуульд явж байна. Мөн ихэнх бүс нутагт бага сургууль дахь хүйсийн ялгаа үгүй болжээ. 2016 оны сонгуулийн дараа Монгол Улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь 17,1% болж, бүс нутгийн дундаж болох 18,8%-д дөхөж очсон байна. Гэвч Мянганы хөгжлийн зорилт болох эмэгтэйчүүдийн 30%-ийн квотод хүртэл, бүр цаашлаад бүс нутгийн улсуудын зорилт байх учиртай хүйсийн тэгш төлөөллийг бүрэн хангах үзүүлэлтэд хүртэл бидэнд хийх зүйл их байна.

ТХЗ нь 20 жилийн өмнө МХЗ-уудыг тодорхойлж батлах үед төдийлөн анхааралд өртөөгүй асуудлуудыг хөндөж, шинэ санаачилга, сэдлийг түгээж байна. Тухайлбал, уурамьсгалын өөрчлөлт, аюулгүй байдлын асуудлууд болон хямралыг давах мөн эмэгтэйчүүдийг эдгээрийг шийдвэрлэхэд илүү ихээр татаж оролцуулах зэргийг дурдаж болно.

Шинэ глобал зорилтуудад эмэгтэйчүүдийг өөрчлөлт шинэчлэлийг бүтээх нэг гол оролцогч мөн хөгжлийн үйл явцыг удирдах хүч хэмээн онцолжээ. Энэ нь эмэгтэйчүүдийг хөгжлийн төлөөх ажлын ашиг шимийг хүртэгчид гэж харах хуучинсаг сэтгэлгээнээс ангижирч, олон нийтийг эмэгтэйчүүд бол асуудлыг шийдэх шийдлийн нэг хэсэг, түүнд оролцогч хэмээх өнцгөөс харахад чиглүүлж байна.

Олон улсын туршлагаас харахад, эмэгтэйчүүд аливаа улсын эсвэл орон нутгийн парламентад ч байна уу, олон нийтийн

2016 оны сонгуулийн дараа Монгол Улсын парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь 17,1% болж, бүс нутгийн дундаж болох 18,8%-д дөхөж очсон байна. Гэвч Мянганы хөгжлийн зорилт болох эмэгтэйчүүдийн 30%-ийн квотод хүртэл, бүр цаашлаад бүс нутгийн улсуудын зорилт байх учиртай хүйсийн тэгш төлөөллийг бүрэн хангах үзүүлэлтэд хүртэл бидэнд хийх зүйл их байна.

*Шинэ глобал
зорилтуудад
эмэгтэйчүүдийг
өөрчлөлт
шинэчлэлийг бүтээх
нэг гол оролцогч
мөн хөгжлийн үйл
явцыг удирдах хүч
хэмээн онцолжээ. Энэ
нь эмэгтэйчүүдийг
хөгжлийн төлөөх
ажлын ашиг шимийг
хүртэгчид гэж
харах хуучинсаг
сэтгэлгээнээс
ангигирч, олон
нийтийг эмэгтэйчүүд
бол асуудлыг шийдэх
шийдлийн нэг хэсэг,
түүнд оролцогч
хэмээх өнцгөөс
харахад чиглүүлж
байна.*

захиргааны байгууллагад эсвэл хувийн салбарт ч байна уу хамаагүй, шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа бол юун түрүүнд эрүүл мэнд болон боловсролын асуудал, хүүхэд асрах асуудал, хот тосгоныг цэвэр болон бохир устай холбох, түүнчлэн байгал орчны хамгаалал зэрэг чухал асуудлуудын хүрээнд бодлогын өөрчлөлт гаргахын төлөө ажилладаг нь ажиглагдана. Харин эрэгтэй улс төрчдийн хувьд эдгээр сэдвийг төдийлөн чухалд тооцдоггүй ажээ. НҮБХХ-ийн дарга Хелен Кларкийн хэлсэнчлэн, хэрвээ эмэгтэйчүүд олон нийтийн амьдралд оролцохгүй байвал эдгээр сэдвүүд ч мөн үл үзэгдэгч болон хувирдаг байна.

2012-2016 оны хооронд Монголын парламент дахь эмэгтэйчүүдийн албан бус бүлэг олон чухал хуулийг санаачилжээ. Жишээлбэл, тэд тамхины тухай хууль, эрүүгийн хууль болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль зэрэг олон талт хуулийг санаачилж, боловсруулж эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах санаачлагыг хэрэгжүүлсэн байна. Ингэснээр эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгэл оноох эрх зүйн зохицуулалтыг сайжруулсан. Монголын парламентын эдгээр эмэгтэй төлөөлөгчдийн зарим нь өнөөдөр энэ чуулганд оролцож байгаад би их баяртай байна.

Төгсгөлд нь би та бүхэнд дахин нэг удаа сануулмаар байна. ТХЗ-ууд нь тэгш бус байдлыг хөгжлийн хамгийн том саад хэмээн үзэж, үүнтэй системтэйгээр тэмцэж чадсан цагт л 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр зорьж байгаа эдгээр зорилтууд биеллээ олж, хүн төрөлхтөн болоод манай гаригийн хувьд ул суурьтай өөрчлөлтийг авчирч чадна хэмээн үзэж байна. Эмэгтэйчүүдийг өөрчлөлт шинэчлэлийн нэг оролцогч хэмээн харж, тэдний хөгжилд хөрөнгө оруулах нь нийт нийгмийг хамарсан, үе дамжсан, ашиг тус болон давуу талыг бий болгодог гэдгийг бид олон жишээнээс харж болно. Иймд хүйсийн тэгш байдал нь тэгш бус байдалтай тэмцэх бүх кампанит ажлын үндсэн цөм нь байх учиртай. Энэ зарчим ТХЗ-уудын хувьд ч мөн адил үйлчилнэ.

Хилари Клинтонь ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээсээ урьд нэгэн удаа хэлж байсанчлан – “Үүнийг хийх нь зөвөөс гадна ухаалаг хэрэг юм”.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Беате Транкманн

*НҮБ-ын болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн
Монгол дахь Суурин төлөөлөгч*

ЧУУЛГАНЫ ХҮРЭЭН ДЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД

Монгол-Германы XIV чуулган “Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоогоор дамжуулан ардчиллыг бэхжүүлэх нь” сэдвийн хүрээнд 2016 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа. Тус чуулганд оролцон илтгэл тавьсан эрхэм зочид, байр сууриа илэрхийлсэн панелистууд, бусад оролцогчдын зүгээс дэвшүүлсэн саналыг нэгтгэн дараах санал зөвлөмжийг гаргаж байна.

Улс төрийн шийдвэр гаргалтад эмэгтэйчүүдийн оролцоог мохоож, саад учруулж буй суурь хоёр хүчин зүйлийг оролцогчид цохон хэлэлцлээ. Нэгдүгээрт, эрэгтэй эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх ролийн талаар тогтсон хэвшмэл сэтгэлгээ, түүнд суурилсан ялгаварласан шинжтэй үзэл хандлага, хоёрдугаарт, улс төрийн сонгууль, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах болсон өсөн нэмэгдэж буй зардал, санхүүгийн хүндрэлтэй байдал, түүнийг тойрсон авлигажсан нөхцөл байдал нь нийгмийн олон янз байдлын хүмүүс тэр дундаа эмэгтэйчүүд улс төрийн шийдвэр гаргалтад бодитой оролцох, улмаар Монгол Улсын ардчиллыг хүчирхэгжүүлэн бэхжүүлэхэд саад тотгор болж байна.

Чуулганы оролцогчдоос шийдвэр гаргагчид, улс төрийн намууд болон манлайлагч эмэгтэйчүүддээ хандсан дараах санал санаачлагуудыг дэвшүүллээ.

Шийдвэр гаргагчдад хандан дараах зөвлөмжийг гаргаж байна:

- Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын өмнө авсан үүрэг амлалт, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрүүдэд тусгагдсан эмэгтэйчүүдийн тэгш эрхийг бодитой эдлүүлэх, шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн тэгш оролцоог хангах талаар шийдвэртэй алхамууд хэрэгжүүлэх;
- Ажил эрхлэлт, гэр бүл төлөвлөлтийг эрэгтэй, эмэгтэй хүн аль аль нь тэгш үүрэг, оролцоотойгоор хослуулан авч явах нийгмийн, ажил эрхлэлтийн бодлого, хууль зүйн орчныг сайжруулах;
- Улс төрийн шийдвэр гаргалт болон бусад хүрээнд эмэгтэйчүүдийн бодит оролцоог бэхжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийг, тухайлбал Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, холбогдох хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийг сайжруулах;
- Сонгуулийн тухай хуульд байсан нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн байх шаардлагыг бууруулах гэх мэт зарчимгүй байдлыг дахин давтахгүй байх, улс төрийн хүсэл зоригоо илэрхийлж тус квотыг эргэн сэргээх, улс төрийн намын эрх зүйн зохицуулалттай уялдуулж тусгах.

Улс төрийн намуудад хандан дараах зөвлөмжийг гаргаж байна:

- Улс төрийн нам иргэдийн олон янз бүлгийн төлөөлөл, тэр дундаа эмэгтэйчүүдэд нээлттэй, тэдний бодитой оролцоог



Ажил эрхлэлт, гэр бүл төлөвлөлтийг эрэгтэй, эмэгтэй хүн аль аль нь тэгш үүрэг, оролцоотойгоор хослуулан авч явах нийгмийн, ажил эрхлэлтийн бодлого, хууль зүйн орчныг сайжруулах шаардлагатай.

Манлайлагч
эмэгтэйчүүд улс
төрийн нам болон
үе хооронд, мөн
шийдвэр гаргалтын
түвшин хооронд
эмэгтэйчүүдийн эв
санааны нэгдэл,
хамтын ажиллагаагаа
бэхжүүлэх, харилцан
суралцах, дэмжих,
шинэ үеийг тогтмол
бэлтгэж байхад
анхаарах, үлгэр
дууриалал үзүүлэх
хэрэгтэй.

бэхжүүлэхэд чиглэсэн про-актив бодлого, дотоод бүтэц, дүрэм журмаа тодорхойлох, намуудын шинэчлэлийн нэн тэргүүний зорилтуудын хүрээнд авч үзэх;

- Бүх шатны намын дотоод шийдвэр гаргах бүтцэд хүйсийн тэгш байдлыг хангах талаар тодорхой квотын, хүйсээр ээлжлэх гэх мэт зохицуулалтуудыг нэвтрүүлэх;

- Намаас улс төрийн сонгуульд нэр дэвшүүлэх дүрэм журам, шийдвэр гаргалт ил тод байх, холбогдох хууль тогтоомжийг давуулан хүйсийн тэгш байдлыг хангах;

- Эмэгтэйчүүдийн манлайллын ур чадварыг бэхжүүлэх, шинэ үеэ бэлтгэхэд чиглэсэн дэмжлэг, хөтөлбөрүүдийг зохион байгуулах.

Манлайлагч эмэгтэйчүүддээ хандан дараах зөвлөмжийг гаргаж байна:

- Манлайлагч эмэгтэйчүүд улс төрийн нам болон үе хооронд, мөн шийдвэр гаргалтын түвшин хооронд эмэгтэйчүүдийн эв санааны нэгдэл, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, харилцан суралцах, дэмжих, шинэ үеийг тогтмол бэлтгэж байхад анхаарах, үлгэр дууриалал үзүүлэх;

- Улс төрийн хүрээн дэх шударга бус байдалтай үл эвлэрэх, ардчилал, төлөөллийн зарчмыг үгүйсгэсэн зохион байгуулалт, соёл, дүрэм журамтай тэмцэх, шударга өрсөлдөөн, бодит оролцоо бүхий улс төрийн институтуудыг бэхжүүлэхэд хувьд нэмрээ оруулахыг уриалж байна.

Зөвлөмжийг боловсруулсан: Х.Номингэрэл

Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ-ын УЗ-ийн дарга

ТӨГСГӨЛ ҮГ

Монгол-Германы Чуулган (МГЧ) нь ХБНГУ болон Монгол Улсын хоорондох харилцан ярианы хамгийн чухал формат юм. Конрад-Аденауэр-Сангийн хувьд жил бүр Берлин, Улаанбаатар хотуудад ээлжлэн болдог МГЧ-ыг хамтран зохион байгуулж буй нь нэр төрийн хэрэг билээ. Ээлжит чуулган болгоноор бид хоёр орны сонирхлыг хамарсан сэдвийг хэлэлцүүлэхээр эрэлхийлдэг. 2016 онд Улаанбаатар хотноо зохиогдсон 14 дэх удаагийн чуулганаар бид “Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоогоор дамжуулан ардчиллыг бэхжүүлэх нь” гэсэн сэдвийг сонгосон. Тус чуулганы зорилго нь харилцан бие биенээсээ тасралтгүй суралцах болон хамтдаа аливаа асуудлын шийдлийг олох юм. Энэ жилийн чуулганаар бид 200 гаруй оролцогчидтойгоор улс төрийн алба хашиж буй эмэгтэйчүүдийг дэмжих, нийгэм эдийн засаг дахь эмэгтэйчүүдийн үүрэг роль болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн талаар санал бодлоо солилцсонд тун баяртай байна. Чуулганы явцад эдгээр сэдвүүд манай 2 орны нийгэмд ямар чухал байгааг, түүнчлэн бид эдгээр сэдвийн хүрээнд хэрхэн бие биенээсээ суралцаж болохыг тодхон харлаа.

Ардчилал бол хамтын үйл. Нэн ялангуяа шийдвэр гаргах түвшинд нийгмийн болон хүн амын бүлэглэлүүдийн тэнцвэртэй төлөөллийг тогтвортой хангаж чадсанаар л бид ардчиллын үйл явцыг амжилттай үргэлжлүүлж чадна. Германд ч, Монголд ч эмэгтэйчүүд нийгмийг хөдөлгөх үндсэн хүч нь болж байдаг. Тэд ажлын талбартаа ч, гэр бүл дотроо ч хариуцлагыг үүрдэг. Гэвч манай хоёр оронд эмэгтэйчүүдийн улс төр дэх төлөөлөл чамлалттай хэвээр байна. Монгол-Германы XIV Чуулган болон түүний дагалдах арга хэмжээнүүдээр дамжуулан бид хоёр орны удирдах албан тушаалын эмэгтэйчүүдэд бие биенээсээ харилцан туршлага судлах боломжыг олголоо. Түүнээс гадна бид монголын олон нийтэд улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийг дэмжихийн утга учир, давуу талын тухай тодорхой мессэж илгээлээ. Энд дэвшүүлсэн саналуудыг зөвхөн монголын болон германы олон нийтэд дуулгах бус улмаар улс төр, нийгэм, эдийн засаг болон шинжлэх ухааны салбарын шийдвэр гаргах түвшний төлөөлөгчдөд хүргэж үйл хэрэг болгоход нь түлхэц үзүүлдэг нь аль хэдийн тус чуулганы уламжлал болжээ.

Энэ жилийн чуулганыг өргөн олонд нээлттэй зохион байгуулсан нь тус чуулганы утга учир огтхон ч буураагүй, харин ч цаашид хоёр орны хамгийн чухал хэлэлцүүлгийн талбар хэвээр байхыг харууллаа. Монгол-Германы Чуулган цаашид ч Герман-Монголын харилцаанд чухал хувь нэмэр оруулсаар байх болно.

Др. Даниел Шмюкинг

Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч



*Ардчилал бол
хамтын үйл.
Нэн ялангуяа
шийдвэр гаргах
түвшинд нийгмийн
болон хүн амын
бүлэглэлүүдийн
тэнцвэртэй
төлөөллийг
тогтвортой хангаж
чадсанаар л бид
ардчиллын үйл
явцыг амжилттай
үргэлжлүүлж чадна.*

МОНГОЛ-ГЕРМАНЫ XIV ЧУУЛГАН ФОТО ДУРАНД



МОНГОЛ-ГЕРМАНЫ XIV ЧУУЛГАН ФОТО ДУРАНД





Монгол орон бидний хувьд:
“БАЙГАЛД ОРШИХ ТҮР ХУГАЦААНЫ ЭХ ОРОН”

“МОНГОЛ/ГЕРМАН ОРОН МИНИЙ ХУВЬД...” ФОТО ЦУВРАЛААС

Герман орон бидний хувьд:
“ХӨГЖИЛ, ЧАНАР”



Монгол орон бидний хувьд:
“НАЙЗУУД”

Герман орон бидний хувьд:
“МАШ ЦЭВЭРХЭН БАЙДАЛ, ЦАГ БАРИЛТ”



Монгол орон бидний хувьд:
“ТАЛ НУТАГ, ЭРХ ЧӨЛӨӨ”



Герман орон бидний хувьд:
"ХАРИУЦЛАГАТАЙ ТАЛ"

"МОНГОЛ/ГЕРМАН ОРОН МИНИЙ ХУВЬД..." ФОТО ЦУВРАЛААС

Монгол орон миний хувьд:
"АГУУ ЭРХ ЧӨЛӨӨ"



Герман орон бидний хувьд:
"ЧАНАР, ЦАГ"

Герман орон бидний хувьд:
"ХОЁР ДОХ ЭХ ОРОН"



Герман орон миний хувьд:
"КАС, АНГЕЛА МЕРКЕЛ,
БОЛОВСРОЛЫН СИСТЕМ"

Герман орон миний хувьд:
"ХӨЛБӨМБӨГ"



Монгол орон миний хувьд:
"ХЯТАД, ОРОС ГЭХ ХОЁР ИХ ГҮРНИЙ ДУНД
НАЙРСАГ ЗАРЧМААР ОРШИЖ БҮЙ
ХҮНДЭТГЭЛ ТӨРҮҮЛЭМ ОРОН.
МАШ САЙХАН НУТАГ!"

Герман орон миний хувьд:
"ЦАГ БАРИЛТ"



"МОНГОЛ/ГЕРМАН ОРОН
МИНИЙ ХУВЬД..."
ФОТО ЦУВРАЛААС

Герман орон миний хувьд:
"ЗӨВ ЭДИЙН ЗАСГИЙН ЗАГВАР"



Монгол орон бидний хувьд:
"ХОЁР ДОХ ЭХ ОРОН"





<http://www.kas.de/mongolei/>